MOORE

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

MOORE

Агуулга

Группийн талаарх мэдээлэл
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 1
НЭГТГЭСЭН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН 5
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН 6
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 7
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 8
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 10
1. Ерөнхий мэдээлэл 10
2. Группийн үйл ажиллагааны орчин 10
3. Материаллаг НББ-ийн бодлогууд 11
4. Гол чухал НББ-ийн тооцоолол ба үнэлэмж 13
5. Үйл ажиллагааны сегментүүд 14
6. Борлуулалтын орлого 15
7. Бусад орлого, олз 16
8. Зардал 16
9. Санхүүгийн орлого ба зардал 18
10. Орлогын татварын зардал 19
11. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 21
12. Бараа материал 23
13. Урьдчилгаа 23
14. Худалдааны болон бусад авлага 23
15. Бусад санхүүгийн хөрөнгө 24
16. Урт хугацаат хөрөнгө оруулалт 26
17. Үндсэн хөрөнгө 27
18. Биет бус хөрөнгө 29
19. Түрээс (түрээслэгчээр) 31
20. Худалдааны болон бусад өр төлбөр 34
21. Хувьцаат капитал 35
22. Капиталын удирдлага 37
23. Хуримтлагдсан ашиг ба ногдол ашиг 37
24. Бодит үнэ цэний хэмжилт 38
25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага 38
26. Холбоотой талууд 43
27. Үүрэг хариуцлага ба бусад хуулийн шаардлага 46
28. Балансын дараах үйл явдал 46

MOORE

Группийн талаарх мэдээлэл

Толгой компанийн нэр	Инновэйшн Инвестмент Хувьцаат компани
Үүсгэн байгуулах шийдвэр	Инновэйшн Инвестмент ХК нь 2017 оны 04 сарын 20-ны өдрийн үүсгэн байгуулагчдын шийдвэрийн дагуу Монгол улсын хуулийн хүрээнд үүсгэн байгуулагдсан.
	Компани нь Монгол улсын бүртгэлийн газарт 2017 оны 05 сарын 10-ны өдөр бүртгэгдсэн.
	2023 оны 12 сард хөрөнгийн бирж дээр IPO хийж нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд Монголын хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй хувьцаат компани юм.
	Улсын бүртгэлийн дугаар 9007001023.
	Байгууллагын регистрийн дугаар 6183948.
Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ-ийн дарга А. Баттамир
	ТУЗ-ийн гишүүн Б. Анхболд
	ТУЗ-ийн гишүүн Б. Чулуунсүх
	ТУЗ-ийн гишүүн Г. Хатанболд
	ТУЗ-ийн гишүүн У. Мөнхзул
	ТУЗ-ийн гишүүн У. Наранбаатар
	ТУЗ-ийн хараат бус гишүүн Т. Дашцэрэн
	ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш. Уянга
	ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Нандин Эрдэнэ
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О. Маралмаа
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал Б. Энхболд
	Ерөнхий нягтлан бодогч С.Ундармаа
Бүртгэлтэй хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма ганди, НМ төв, 8 давхар
Аудиторууд	Мүүрь Аудит ХХК
	Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид

Инновэйшн Инвестмент ХК
Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Ганди
гудамж, "Эн Эм" оффис, 8давхар,
Утас: (976) 7610-2211, И-мэйл: info@qpay.mn

2026.3.20 № 26/13
танай -ны №

Мүүрь Аудит ХХК-д

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Инновэйшн Инвестмент ХК-ийн удирдлага бид нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад Хараат бус аудиторын тайлан дахь *Санхүүгийн тайлангийн аудитад удирдлагын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт дурдсан үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч байна гэдгийг мэдэгдэж байна.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна. Компанийн удирдлагаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

УЛААНБААТАР ХОТ
ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК
ШТШ867 8183948 9026070240

ТУЗ-н ДАРГА
А.БАТТАМИР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЭНХБОЛД

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
С.УНДАРМАА

MOORE

Мүүрь Аудит ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо Олимпийн гудамж 7/3,
Центрум төв 7 давхар, 701 тоот

Утас : +976 7015 0003
Факс: +976 7015 0003
И-мэйл: info@moore-mongolia.mn

www.moore-mongolia.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид, Инновэйшн Инвестмент ХК болон түүний охин компаниуд (хамтад нь Групп гэх)-ын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группийн 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-д заасан олон нийтийн ашиг сонирхлын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагууд болон Монгол улсын Аудитын тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн аудитад хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагууд болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн дагуу тавигддаг бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хүрээнд тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг бүхэлд нь авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

Аудитын гол асуудал	Бид аудитаар аудитын гол асуудлыг хэрхэн авч үзсэн
Тайлант жилд Групп 38,125,353 (2024: 26,231,629) мянган төгрөгийн үйлчилгээний орлоготой ажилласан байна. (Тод.6) Орлого хүлээн зөвшөөрөлтийн үйл явцын нарийн төвөгтэй байдлаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэл үүсэх эрсдэл өндөр гэж үзсэн тул гол асуудлаар тайлагнасан.	Группийн хувьд харилцагч ба мерчантууд нь QR кодыг хэр зэрэг идэвхтэй ашиглан, цахим шилжүүлэг хийхээс үйлчилгээний орлого хамаарах бөгөөд маш их хэмжээний ажил гүйлгээний дүнгээс шимтгэлийн орлого ба шимтгэлийн буцаалтын зардлыг тооцоолдог. Орлого нь тухайн агшинд хэрэгждэг бөгөөд тооцоолол хийх датаны иж бүрэн байдал, тооцооллын найдвартай, үнэн зөв байдал чухал учир бид ихээхэн анхаарал хандуулсан. Бид дараах горимуудыг гүйцэтгэсэн: • Орлого хүлээн зөвшөөрөлтийн бодлого ба тууштай байдал, аргачлал өгөгдлийг зөв хэрэглэж байгаа эсэхийг үнэлсэн. • Датаны иж бүрэн байдалд хяналтын тест хэрэгжүүлсэн. • Сонгосон хугацааны шимтгэлийн тооцооллын үнэн зөвийг давтан тооцоолж шалгасан. • Билл нөхцөлтэй харилцагчдын тооцоо иж бүрэн хийгдсэн эсэхийг түүвэрлэн шалгасан. • QR код үүсгэх системд харилцагчтай байгуулсан гэрээний нөхцөл шаардлагыг зөв оруулсан эсэхийг түүврийн аргаар шалгасан. • Мэдээллийн аюулгүй байдал, зөвшөөрлийн функцууд зохистой ажиллаж байгаа эсэхийг үнэлсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийлэлгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, мөн Группийн үйл ажиллагааг зогсоох буюу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний аудитын зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах, мөн бидний дүгнэлтийг багтаасан аудитын тайлан гаргах юм. Үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаа боловч Аудитын

олон улсын стандарт (АОУС)-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл оршин буй тохиолдолд үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба тэдгээр нь дангаараа эсвэл нийлээд тэдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрүүдэд нөлөөлөхөөр байвал тэдгээрийг материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг болгон бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж, мөн аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандана. Бид түүнчлэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг үнэлэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу үзүүлэх аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэнэ, мөн өөрсдийнхөө дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай зохистой нотолгоо олж авна. Залилан нь үгсэн хуйвалдах, бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, гуйвуулах эсвэл дотоод хяналтыг үл хэрэгсэх зэргийг багтаасан байж болох учраас залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус, тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн Группийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадварт томоохон эргэлзээ үүсгэхүйц үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлнэ, мөн нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар үндсэн гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг тусгасан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт илэрхийлэхийн тулд Группийн доторх аж ахуйн нэгжүүд эсвэл бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай зохистой аудитын нотолгоо олж авдаг. Бид Группийн аудитын ажлыг удирдан чиглүүлж, хянаж, гүйцэтгэхэд хариуцлага хүлээнэ. Бид өөрсдийн аудитын дүгнэлтдээ дангаар хариуцлага хүлээнэ.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа томоохон сул

талыг багтаагаад илрүүлсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажилласан талаарх мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид хараат бус байдлын хүрээнд бүх харилцаа холбоо болон бодолцож үзвэл зохих бусад асуудлуудаар, хамааралтай бол, хараат бус байдалд учирсан сөрөг нөлөөнүүдийг арилгахын тулд авсан арга хэмжээнүүд, хэрэглэсэн хамгаалалтуудын талаар тэдгээр хүмүүстэй харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн үлэмж нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар тухайн асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд, аудиторын тайландаа тухайн асуудлаар харилцах нь уг харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж бид үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр гол асуудлыг аудиторын тайландаа тусгадаг.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт 2025 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон Группийн жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудитын тайлан үүнд хамаарахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд илэрхийлсэн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй.

Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй. Группийн 2025 оны жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангаас хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна. Хэрэв жилийн тайлантай танилцах үед бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл холбогдох арга хэмжээг дурдан бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх болно.

МҮҮРЬ АУДИТ ХХК

Н. МЯГМАРЖАВ

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Огноо: 2026.03.20

Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Центрум төв, 7 давхар, 701 тоот.

Утас: 976-7015 0003, **И-мэйл**: info@moore-mongolia.mn

НЭГТГЭСЭН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тод.	2025 Аудитлагдсан ₮'000	2024 Аудитлагдсан ₮'000
Борлуулалтын орлого (цэвэр)	6	38,125,353	26,231,629
Борлуулалтын өртөг	8	(19,976,136)	(12,051,045)
Нийт ашиг		***18,149,217***	***14,180,584***
Бусад орлого	7	57,328	69,105
Ерөнхий ба удирдлагын зардал	8	(3,514,222)	(1,941,550)
Борлуулалт, маркетингийн зардал	8	(1,465,571)	(805,563)
Бусад зардал	8	(436,483)	(48,929)
Үйл ажиллагааны ашиг		*12,790,269*	*11,453,647*
Санхүүгийн орлого	9	2,019,583	1,608,190
Санхүүгийн зардал	9	(141,249)	(1,703)
Цэвэр санхүүгийн орлого		*1,878,334*	*1,606,487*
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	39,866	(13,528)
Хөрөнгө оруулалт борлуулсны олз	7	685,663	-
Татварын өмнөх ашиг		15,394,132	13,046,606
Орлогын татварын зардал	10	(1,954,931)	(3,020,452)
Тайлант жилийн цэвэр ашиг		**13,439,201**	**10,026,154**
Үүнээс:			
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох		**13,439,201**	**10,026,154**
Үндсэн нэгж хувьцаанд ногдох ашиг, төгрөг		**72.69**	**54.23**

MOORE

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тод.	2025 Аудитлагдсан ₮'000	2024 Аудитлагдсан ₮'000
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11	24,107,941	14,653,598
Худалдааны болон бусад авлага	14	3,101,491	3,010,240
Орлогын албан татварын авлага	10	262,979	-
Урьдчилж төлсөн зардал тооцоо	13	133,652	114,825
Бусад санхүүгийн хөрөнгө	15	2,826,470	944,832
Бараа материал	12	3,793	2,737
Эргэлтийн хөрөнгийн дүн		*30,436,326*	*18,726,232*
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	17	1,558,625	1,229,171
Биет бус хөрөнгө	18	404,630	505,973
Ашиглах эрхтэй хөрөнгө	19	825,614	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	16	669,400	1,250,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	10	304,969	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		*3,763,238*	*2,985,144*
Нийт хөрөнгө		**34,199,564**	**21,711,376**
Эргэлтийн өр төлбөр			
Худалдааны болон бусад өр төлбөр	20	2,344,631	2,269,607
Орлогын албан татварын өр төлбөр	10	-	392,494
Түрээсийн өр төлбөр	19	368,112	-
Ногдол ашгийн өглөг	22	50	3,697,783
Гэрээний өр төлбөр	6	13,007	-
Эргэлтийн өр төлбөр		*2,725,800*	*6,359,884*
Эргэлтийн бус өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр	10	-	71,576
Түрээсийн өр төлбөр	19	504,977	-
Эргэлтийн бус өр төлбөр		*504,977*	*71,576*
Нийт өр төлбөр		**3,230,777**	**6,431,460**
Цэвэр хөрөнгө		**30,968,787**	**15,279,916**
Өмч			
Хувьцаат капитал	21	4,622,229	4,284,927
Нэмж төлөгдсөн капитал	21	5,197,040	3,554,513
Хуримтлагдсан ашиг	22	21,149,518	7,440,476
Нийт өмч		**30,968,787**	**15,279,916**

MOORE

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тод.	Энгийн хувьцаа ₮'000	Нэмж төлөгдсөн капитал ₮'000	Хуримтлагд-сан ашиг ₮'000	Нийт ₮'000
2024.01.01-ний үлдэгдэл		4,622,229	4,653,188	8,368,940	17,644,357
Өмчид гарсан өөрчлөлт	21,22	(337,302)	(1,098,675)	440,101	(995,876)
Зарласан ногдол ашиг	22	-	-	(11,394,719)	(11,394,719)
Тайлант жилийн ашиг		-	-	10,026,154	10,026,154
2024.12.31-ний үлдэгдэл		**4,284,927**	**3,554,513**	**7,440,476**	**15,279,916**
Өмчид гарсан өөрчлөлт	21,22	337,302	1,642,527	269,841	2,249,670
Зарласан ногдол ашиг	22	-	-	-	-
Тайлант жилийн ашиг		-	-	13,439,201	13,439,201
2025.12.31-ний үлдэгдэл		**4,622,229**	**5,197,040**	**21,149,518**	**30,968,787**

MOORE

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тод.	2025 Аудитлагдсан ₮'000	2024 Аудитлагдсан ₮'000
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого		*42,212,344*	*28,926,589*
Үйлчилгээ үзүүлсний орлого	6	41,722,395	27,482,043
Бусад орлого		569	233
Бусад мөнгөн орлого		489,380	1,444,313
Мөнгөн зарлага		*(31,934,027)*	*(20,131,650)*
Ажиллагсдад төлсөн		(2,737,435)	(1,558,490)
Нийгмийн даатгалд төлсөн		(758,665)	(414,988)
Татварт төлсөн		(7,852,369)	(5,300,248)
Үйлчилгээний шимтгэлийн буцаалт	8	(17,268,122)	(10,620,995)
Бусад мөнгөн зарлага		(3,317,436)	(2,236,929)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**10,278,317**	**8,794,939**
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого		*7,493,272*	*1,975,402*
Хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгө		590	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас хүлээн авсан мөнгө	16,21	3,483,658	414,630
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны төлөлт		1,975,061	267,021
Хүлээн авсан хүү	9	1,979,501	1,228,103
Хүлээн авсан ногдол ашиг	7	54,462	65,648
Мөнгөн зарлага		*(4,718,582)*	*(3,609,438)*
Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн		(1,169,400)	(2,215,903)
Биет ба биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	17,18	(606,382)	(1,387,015)
Хадгаламж нэмэгдүүлсэн	15	(981,638)	-
Бусдад олгосон зээл		(1,961,162)	(6,520)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**2,774,690**	**(1,634,036)**

MOORE

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Тод.	2025 Аудитлагдсан ₮'000	2024 Аудитлагдсан ₮'000
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлого		-	*103,027*
Зээл авсан		-	103,027
Мөнгөн зарлага		*(3,638,444)*	*(6,613,111)*
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашиг	23	(3,183,518)	(6,575,070)
Төлсөн түрээсийн өр	19	(454,926)	(38,041)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(3,638,444)**	**(6,510,084)**
Мөнгөн хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		39,780	2,959
Тайлант жилийн бүх цэвэр мөнгөн гүйлгээ		**9,454,343**	**653,778**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11	14,653,598	13,999,820
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11	24,107,941	14,653,598

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. Ерөнхий мэдээлэл

Группийн толгой компани нь Инновэйшн Инвестмент ХК бөгөөд энгийн хувьцааг нь 100 хувь эзэмшиж, хяналт хэрэгжүүлдэг ККТТ ХХК, Дижитал мерчант сервисэс ХХК тус тус нэгтгэгддэг.

Инновэйшн Инвестмент ХК нь 2017 оны 04 сарын 20-ны өдөр үүсгэн байгуулагчийн шийдвэрээр Монгол улсын хуулийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2023 оны 12 сард хөрөнгийн бирж дээр IPO хийж нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилсөн бөгөөд Монголын хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй хувьцаат компани юм.

Улсын бүртгэлийн дугаар 9011244113, регистрийн дугаар 6183946.

Группийн үндсэн үйл ажиллагаа нь мэдээлэл технологийн үйл ажиллагаа, программ хангамжийн үйлчилгээ, техник хангамжийн үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа ба дараах тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн тушаалын дагуу охин компани болох ККТТ ХХК-ийн нэр дээр "Аутсорсингийн үйлчилгээ авах" тусгай зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай,
- Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А-245 тоот тушаалын дагуу охин компани болох ККТТ ХХК-ийн нэр дээр "Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх" тусгай зөвшөөрлийг 4 жилийн хугацаатай.

Группийн албан ёсны бүртгэлтэй хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Ганди, НМ төв, 8 давхар.
Группийн албан ёсны вэб сайт: https://www.i-investment.mn/, https://qr.qpay.mn/

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Группийн толилуулгын валют болох Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүд мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн.

2. Группийн үйл ажиллагааны орчин

Групп нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 13,439,201 (2024: 10,026,154) мян.төгрөгийн цэвэр ашигтай, 2,725,800 (2024: 6,359,884) мян.төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй, 30,436,326 (2024: 18,726,232) мян.төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй ажилласан байна.

ОУ-ын зээлжих зэрэглэл тогтоогч Эс энд Пи агентлагаас Монгол улсын урт хугацааны зээлжих зэрэглэл BB-, төлөвийг "тогтвортой" болгон ахиулж, харин богино хугацааны зээлжих зэрэглэлийг "B" хэвээр үлдээсэн.[1] Тус агентлагийн төсөөллөөр ирэх 2-3 жилийн хугацаанд манай улсын эдийн засгийн өсөлт тогтвортой байх хүлээлттэй байна.

2025 онд эдийн засаг 5.9 хувиар өссөн. Үүнд, хөдөө аж ахуйн салбарын өсөлт өндөр түвшинд хадгалагдсан, аж үйлдвэр, барилгын салбарын идэвхжил нэмэгдсэн, зээсийн баяжмалын олборлолт сайжран уул уурхайн салбарын өсөлт тэлсэн зэрэг нь нөлөөллөө. Хүнсний үнийн өсөлт эрчимжсэнээр 2025 оны жилийн инфляц дунджаар 8.2 хувьтай байсан бол, 2026 онд 7.6 хувь, 2027 онд 6.1 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.

[1] S&P: 2025 оны 10 сарын 30-ны үнэлгээ

2. Группийн үйл ажиллагааны орчин (Үргэлжлэл)

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв сайжирсан ч тодорхой бус байдал үргэлжилсэн хэвээр байна. Улс орнуудын худалдааны тарифын бодлоготой холбоотой тодорхой бус байдал буурсан нь дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөхөөс сайжрах гол шалтгаан болов. Харин геополитикийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь алтны үнэ үргэлжлэн өсөхөд нөлөөлсний зэрэгцээ зэсийн үнэ хүлээлтээс хурдтай нэмэгдсэн нь манай улсын худалдааны нөхцөлд эергээр нөлөөлсөн. Гэвч Ойрх Дорнодын бүх нутагт өрнөж буй мөргөлдөөн нь дэлхийн эдийн засагт томоохон хэмжээний тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Монгол банкны төсөөллөөр 2026 онд эдийн засгийн өсөлт 5.6 хувь байна.
Монгол банк 2025 оны 03 дугаар сард бодлогын хүүг 12% болгож нэмэгдүүлснээс хойш хүүгийн түвшинг тогтвортой хадгалж байна.

3. Материаллаг НББ-ийн бодлогууд

3.1 Тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг дараахаас бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэсэн. Үүнд:

- БҮЦ-ээр хэмжигдсэн өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо ("НББОУСХ")-ноос гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон Тайлбарын дагуу, тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэгдсэн байна. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол улсын Сангийн яамнаас батлагдсан заавар журмыг мөн даган мөрдсөн болно.

Олон Улсын Тогтвортой Байдлын Стандартын зөвлөлөөс 2023 оны 06 сард цаг уурын өөрчлөлтэй холбоотой Тогтвортой байдлын тодруулгын стандартуудыг баталсан. Эдгээр санхүүгийн тайлан нь тус Тогтвортой байдлын тодруулгын стандартаар шаардсан тодруулгыг агуулаагүй бөгөөд дотоодын дүрэм журмаар тус стандартыг дагаж мөрдөхийг шаардсан тохиолдолд Тогтвортой байдлын тодруулгыг бэлтгэнэ.

3.2 Нэгтгэлийн үндэслэл

Санхүүгийн тайлангууд нь Компанийн болон түүний хяналт хэрэгжүүлдэг охин компаниудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

Групп нь тухайн аж ахуйн нэгж дээр хяналт хэрэгжүүлдэг гэж үзэх нөхцөл нь Групп тухайн компани дахь хувь оролцоогоороо дамжуулан хувьсах өгөөж хүртэх эрхтэй бөгөөд мөн тухайн компани дахь эрх мэдлээрээ дамжуулан эдгээр өгөөжид нөлөөлөх чадамжтай байх явдал юм. Ерөнхийдөө, санхүүжигч компанийн холбогдох үйл ажиллагаанд саналын эрхийн талаас илүү хувийг эзэмшсэнээр хяналт тогтоогддог. Групп нь өөр аж ахуйн нэгжид хяналт хэрэгжүүлж байгаа эсэхийг үнэлэхдээ хэрэгжүүлэх боломжтой эсвэл хөрвөх боломжтой боломжит саналын эрхийн оршин байдал болон нөлөөллийг харгалзан үздэг.

Тайлант хугацааны дундуур худалдан авсан охин компаниудын тайлант жилийн үр дүнг Групп хяналт тогтоосон өдрөөс эхлэн, харин тайлант хугацааны дундуур данснаас хассан охин компаниудын тайлант жилийн үр дүнг Групп хяналтаа алдсан өдрийг хүртэлх хугацаагаар нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

3.2 Нэгтгэлийн үндэслэл (Үргэлжлэл)

Компанид тайлант хугацааны дундуур худалдан авсан болон данснаас хассан охин компани байхгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группийн нэгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэсэн компаниудын тусдаа санхүүгийн тайлангуудад үндэслэсэн.

Шаардлагатай бол охин компаниудын баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг группийн бодлоготой нийцүүлэхийн тулд тохируулга хийнэ.

Группийн бүх компаниудын тайлагналын жил нь 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болдог.

Групп доторх компаниудын хооронд хийгдсэн гадаад валютаарх ажил гүйлгээний ханшийн зөрүүний олз гарзаас бусад бүх ажил гүйлгээ болон үлдэгдлийг нэгтгэх явцад устгана. Бодит бус гарзыг тухайн ажил гүйлгээ нь шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэний бууралтын нотолгоогоор хангахаас бусад тохиолдолд устгана.

Харин Групп нь охин компани дахь хяналтаа алдах тохиолдолд, тухайн охин компанитай холбоотой бүх хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцоо болон өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийг үл хүлээн зөвшөөрнө. Үүссэн ашиг буюу алдагдлыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Хяналтаа алдсаны дараа хадгалж үлдсэн аливаа хөрөнгө оруулалтыг тухайн өдрийн бодит үнэ цэнээр хэмжиж хүлээн зөвшөөрнө.

3.3 Гадаад валют

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Группийн бүртгэлийн болон толилуулгын валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр бэлтгэн толилуулсан.

Групп дэх охин компани бүр өөрсдийн үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны валют болох бүртгэлийн валютыг тодорхойлсон. Группийн нэгтгэлд орсон охин компаниудаас группийн толилуулгын валютаас ялгаатай бүртгэлийн валюттай охин компани байхгүй тул бүртгэлийн валютаас толилуулгын валют руу хөрвүүлэлт хийх шаардлага үүсээгүй.

Ажил гүйлгээ ба үлдэгдэл

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээний өдрийн ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлсэн. Тайлагналын өдөр бүр гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар дахин хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг уг БҮЦ-ийг тодорхойлсон өдрийн валютын ханшаар хөрвүүлнэ. Бусад бүх мөнгөн бус зүйлсийг анх хүлээн зөвшөөрсөн өдрийн түүхэн ханшаар нь хөрвүүлнэ.

Валютын ханшийн зөрүүний олз гарзыг ихэвчлэн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө. БҮЦ-р хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийн валютын ханшийн зөрүүний олз, гарзыг тухайн БҮЦ-ийн олз гарзыг бусад дэлгэрэнгүй орлого болон ашиг алдагдлын алинд нь бүртгэдгээс хамаарч тэрхүү ангилалд хүлээн зөвшөөрнө.

3.4 НББ-ийн бодлогуудад орсон өөрчлөлт – шинэ НББ-ийн стандарт болон нэмэлт өөрчлөлтүүд

Группийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх, тайлант хугацаанд хэрэгжиж эхэлсэн шинэ стандартууд байхгүй.

3.5 Батлагдсан боловч хараахан хэрэгжиж эхлээгүй стандартууд

Дараах стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь хараахан хүчин төгөлдөр болоогүй байгаа боловч ирээдүйд Группийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй.

СТОУС 9 болон СТОУС 7-д орсон өөрчлөлтүүд: Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал ба хэмжилттэй холбоотой өөрчлөлтүүд

Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь санхүүгийн өр төлбөрийг цахим шилжүүлгээр барагдуулсан тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх цаг хугацаа, мөн мөнгөн гүйлгээг зөвхөн хүү ба үндсэн төлбөр гэж үзэх, улмаар хөрөнгийг хорогдуулсан өртгөөр ангилах боломжийг олгохтой холбоотой шаардлагуудыг өөрчилсөн.

Групп уг нэмэлт өөрчлөлтийн нөлөөллийг үнэлсээр байгаа ба одоогийн байдлаар, өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх цаг хугацаатай холбоотой өөрчлөлтүүд, санхүүгийн хөрөнгийн ангилалтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд нь Группт нөлөө үзүүлэхээргүй байна. Нэмэлт өөрчлөлтүүд нь 2026 оны санхүүгийн тайланд хамаарна.

СТОУС 18 Санхүүгийн тайлангуудын толилуулга ба тодруулга

Энэ стандарт нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга-ыг бүрэн орлоно. Хуучин стандартын олон шаардлагууд нь хэвээр үлдсэн хэдий ч шинэ стандарт нь Ашиг алдагдлын тайлангийн толилуулгад нөлөө үзүүлж, улмаар мөнгөн гүйлгээний тайланд нөлөөлнө. Энэ стандарт нь түүнчлэн СТОУС-ын бус удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг тодруулахыг шаардахаас гадна үндсэн санхүүгийн тайлангууд болон тодруулга дахь мэдээллийг нэгтгэх болон задлах түвшинд нөлөөлж болзошгүй. СТОУС 18 нь 2027 оны 01 сарын 01 болон түүнээс хойших тайлант үеүдэд хэрэгжих ба буцаан мөрдөх горимоор бүртгэнэ.

Группийн санхүүгийн тайлангуудад материаллаг нөлөө үзүүлэхээр байгаа өөр аливаа шинэ стандартууд эсвэл нэмэлт өөрчлөлтүүд байхгүй.

4. Гол чухал НББ-ийн тооцоолол ба үнэлэмж

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага нь тайлагнасан орлого, зардал, хөрөнгө, өр төлбөр, болон болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулгад нөлөөлөх тооцоолол ба таамаглал хийх шаардлагатай байдаг. Ирээдүйд эдгээрийн бодит үр дүн нь тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлэмжүүд

Групп НББ-ийн бодлогуудыг хэрэглэхдээ дараах томоохон мэргэжлийн шийдлүүдийг гаргасан. Эдгээр мэргэжлийн үнэлэмжүүдийн талаарх дэлгэрэнгүй тодруулгыг холбогдох тодруулгаас нь харах боломжтой.

- Хяналт болон мэдэгдэхүйц нөлөөллийг хэрэгжүүлж буй эсэхийг тогтооход ашигласан үнэлэмж - Тод.26;
- Санхүүгийн хөрөнгүүдийг эзэмшиж буй зорилго болон бизнесийн загварыг тодорхойлох - Тод.15, 16, 25;
- Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг үнэлэх - Тод.14, 15, 25.1;
- Ашиглах эрхтэй хөрөнгө болон холбоотой өр төлбөрийн тооцоололд түрээсийн хугацаа, түрээслэгчийн өсөн нэмэгдэх зээлийн хүүг тодорхойлох - Тод.19;

4. Гол чухал НББ-ийн тооцоолол ба үнэлэмж (Үргэлжлэл)

Тооцооллууд

Дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга хийхэд хүргэж болох томоохон эрсдэлтэй тооцоолол болон таамаглалууд нь дараах байдалтай байна. Бүх тооцооллуудын хувьд өөр төсөөлөл таамаглалуудыг хэрэглэх нь санхүүгийн тайлангуудад тайлагнасан дүнгүүдэд материаллаг өөрчлөлт оруулахад хүргэж болзошгүй юм. Эдгээр төсөөлөл таамаглалуудын шинж чанар, нөлөөллийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох тодруулгаас нь харах боломжтой.

- БҮЦ-ээр хэмжигдсэн хөрөнгийн БҮЦ-ийн хэмжилт:
    - Бусад санхүүгийн хөрөнгө – Тод.15;

БҮЦ-ийн шатлалын мэдээлэл - Тод. 24;

- Санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдал – Тод.14, 25.1;
- Компани түрээслэгч тохиолдолд хүлээгдэж буй түрээсийн хугацаа - Тод.19.

5. Үйл ажиллагааны сегментүүд

Толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь охин компаниудын гүйцэтгэлийг тусад нь үнэлж, хэмждэг бөгөөд тус тусад нь нөөцийн хуваарилалт хийдэг.

Гүйцэтгэх удирдлага нь бизнесийн үйл ажиллагааны явцад олсон орлого, гаргасан зардал, үйл ажиллагааны үр дүнг үйл ажиллагааны ахлах шийдвэр гаргагч (CODM) болох ТУЗ-д тогтмол тайлагнадаг.

ТУЗ нь нөөцийг хуваарилах, гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой шийдвэр гаргах зорилгоор бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр санхүүгийн тайланг хамгийн багадаа улирал бүр хянадаг.

Сегментүүдийн мэдээллийг харуулбал:

	Инновэйшн инвестмент ХК	ККТТ ХХК	Дижитал мерчант сервисэс ХХК
2025.12.31	**₮'000**	**₮'000**	**₮'000**
Санхүүгийн байдал			
Нийт хөрөнгө	8,473,547	24,874,034	4,646,152
Өр төлбөр	38,830	3,158,446	71,670
Цэвэр хөрөнгө	**8,434,717**	**21,715,588**	**4,574,482**
Орлого үр дүн			
Борлуулалтын орлого	-	34,191,148	3,934,206
Үйл ажиллагааны зардал	(1,083,653)	(24,283,877)	(515,672)
Бусад орлого, зардал	1,456,599	1,768,872	196,351
Тайлант үеийн татвар	(47,430)	(1,544,251)	(363,251)
Тайлант үеийн цэвэр ашиг	**325,516**	**10,131,892**	**3,251,634**

5. Үйл ажиллагааны сегментүүд (Үргэлжлэл)

	Инновэйшн инвестмент ХК	ККТТ ХХК	Дижитал мерчант сервисэс ХХК
2024.12.31	**₮'000**	**₮'000**	**₮'000**
Санхүүгийн байдал			
Нийт хөрөнгө	11,846,270	17,290,851	2,095,585
Өр төлбөр	3,737,069	5,707,155	772,737
Цэвэр хөрөнгө	**8,109,201**	**11,583,696**	**1,322,848**
Орлого үр дүн			
Борлуулалтын орлого	-	23,468,441	2,763,188
Үйл ажиллагааны зардал	(705,138)	(14,182,743)	(515,246)
Бусад орлого (зардал)	14,076,221	1,359,566	122,419
Тайлант үеийн татвар	(1,362,734)	(1,420,673)	(237,044)
Тайлант үеийн цэвэр ашиг	**12,008,349**	**9,224,591**	**2,133,317**

6. Борлуулалтын орлого

Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлогыг задлан харуулбал дараах байдалтай байна.

	2025	2024
	₮'000	**₮'000**
Кю-Пэй үйлчилгээний шимтгэлийн орлого	37,954,353	26,114,447
Холболтын үйлчилгээний орлого	171,000	117,182
Худалдан авагчтай байгуулсан гэрээний нийт орлого	***38,125,353***	***26,231,629***

Группийн охин компани болох ККТТ ХХК-ийн цахим системд үүсгэсэн хэвлэмэл болон динамик QR код бүхий цахим төлбөрийн хэрэгслийг иргэн, хуулийн этгээд ашигласан тохиолдолд ажил гүйлгээний дүнгээс шимтгэл, хураамж авч орлогоор бүртгэдэг.

Харилцагч гэрээ байгуулснаар банк харгалзахгүй, төлбөр тооцоо хийх, нэхэмжлэх үүсгэх үйлчилгээг авах боломжтой болох бөгөөд банкнаас бусад QPay-ээр төлбөр хүлээн авдаг бизнес эрхлэгчид Мерчант веб платформ ашиглан өдөр тутмын орлогоо хянах, борлуулалтын тайлангаа харах зэрэг санхүүгийн үйл ажиллагааг удирдаж хянадаг.

Харилцагч гэрээ байгуулснаар Дижитал мерчант сервисэс ХХК нь системийн холболт хийх, ашиглалтын үеийн техникийн болон системийн үйлчилгээг үзүүлдэг.

Мөн Кю-Пэй хэрэглэгч нь Кю-Пэй үйлчилгээгээр дамжуулан Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон бусад байгууллагын үйлчилгээг авч төлбөр төлсөн, шилжүүлэг хийсэн гүйлгээ бүрийн тоогоор Дижитал мерчант сервисэс ХХК нь үйлчилгээний шимтгэл тооцдог.

6. Борлуулалтын орлого (Үргэлжлэл)

	2025 ₮'000	2024 ₮'000
Гэрээний өр төлбөр		
01 сарын 01	-	1,800
Хүлээн авсан мөнгө	24,937,174	14,550,256
Орлогоор хүлээн зөвшөөрсөн дүн	(24,924,167)	(14,552,056)
12 сарын 31	**13,007**	-

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Шууд нөхцөлтэй харилцагчдын шимтгэлийн орлогыг цахим QR код үүсгэж эцсийн хэрэглэгч төлбөр төлөх үед нийт дүнгээр хүлээн зөвшөөрдөг. Дараа нөхцөлтэй гэрээний хувьд сар бүрийн эцэст харилцагчидтай тооцоо нийлж, баталгаажуулсны үндсэн дээр орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Групп Стандартын 5 алхамт загварыг ашиглан орлогоо хүлээн зөвшөөрнө.

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээн дэх гүйцэтгэлийн үүргийг тодорхойлох
3. Ажил гүйлгээний үнийг тодорхойлох
4. Ажил гүйлгээний үнийг хуваарилах
5. Гүйцэтгэлийн үүрэг биелэгдсэн үед орлого хүлээн зөвшөөрөх

Харилцагчдад үзүүлсэн Кю-Пэй үйлчилгээний шимтгэлийн орлогыг нийт дүнгээр хүлээн зөвшөөрч, банкнууд болон операторуудад буцаан хуваарилах шимтгэлийг үйлчилгээний өртгөөр хүлээн зөвшөөрдөг.

Холболтын үйлчилгээний орлогыг үйлчилгээг үзүүлсэн үед хүлээн зөвшөөрдөг.

7. Бусад орлого, олз

	2025 ₮'000	2024 ₮'000
Ногдол ашгийн орлого (Тод.15)	57,328	69,105
Хөрөнгө оруулалт борлуулсны олз (Тод.21)	685,663	-
Нийт бусад орлого	***742,991***	***69,105***

8. Зардал

	2025 ₮'000	2024 ₮'000
Борлуулалтын өртөг	(19,976,136)	(12,051,045)
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,514,222)	(1,941,550)
Борлуулалт, маркетингийн зардал	(1,465,571)	(805,563)
Бусад зардал	(436,483)	(48,929)
Нийт үйл ажиллагааны зардал	***(25,392,412)***	***(14,847,087)***

8. Зардал (Үргэлжлэл)

Үйл ажиллагааны нийт зардлыг төрлөөр нь харуулбал:

	2025	2024
	₮'000	₮'000
Үйлчилгээний өртөг*	(18,632,536)	(11,146,125)
Цалин, НДШ-ийн зардал	(4,042,540)	(2,171,215)
Элэгдэл хорогдол	(885,089)	(317,871)
Маркетинг идэвхижүүлэлтийн зардал	(475,011)	(285,952)
Түрээсийн зардал	(23,401)	(230,978)
Мэргэжлийн үйлчилгээ	(274,145)	(227,748)
Үйл ажиллагааны бусад зардал	(623,208)	(418,269)
Үйл ажиллагааны бус бусад зардал	(436,482)	(48,929)
Нийт үйл ажиллагааны зардал	***(25,392,412)***	***(14,847,087)***

Чиг үүргээр ангилсан зардлыг төрлөөр харуулбал:

Бусад зардал

	2025	2024
	₮'000	₮'000
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	(11,049)	(3,622)
Найдваргүй авлагын зардал (Тод.25)	(87,991)	(29,028)
Хандивын зардал	(299,287)	-
Бусад үйл ажиллагааны бус зардал	(38,156)	(16,279)
	(436,483)	**(48,929)**

Групп нь тайлант онд 299,287 мянган төгрөгийг хандивын үйл ажиллагаанд зарцуулсан. Үүнээс Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 болон 20.1 дэх заалтуудад үндэслэн 285,846 мянган төгрөгийн зардлыг татвар ногдуулах орлогоос хасагдах зардалд оруулан тооцсон. (Тод.10)

Борлуулалтын өртөг

	2025	2024
	₮'000	₮'000
Цалин, НДШ-ийн зардал	(1,317,627)	(904,920)
Үйлчилгээний өртөг*	(18,074,168)	(11,146,125)
Хяналтын зардал	(320,965)	-
Шилэн кабель, сүлжээний зардал	(237,402)	-
Холболтын үйлчилгээний өртөг	(16,883)	-
Бусад үйлчилгээний зардал	(9,091)	-
	(19,976,136)	**(12,051,045)**

*Үйлчилгээний өртөгт оператор байгууллага, арилжааны банкнуудад төлсөн төлбөр багтсан.

8. Зардал (Үргэлжлэл)

Ерөнхий удирдлагын зардал

	2025 ₮'000	2024 ₮'000
Ажилчдын цалингийн зардал	(1,546,313)	(718,834)
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	(189,185)	(89,698)
Элэгдэл, хорогдлын зардал	(885,089)	(317,871)
Мэргэжлийн үйлчилгээний зардал	(274,145)	(227,748)
Ёслол хүндэтгэлийн зардал	(108,826)	(72,395)
Ашиглалтын зардал	(96,563)	(19,886)
Лицензийн төлбөр	(84,037)	(48,580)
Ажилчдын хоолны зардал	(79,456)	(56,351)
Хүний нөөцийн үйл ажиллагааны зардал	(56,065)	(55,485)
Томилолтын зардал	(44,951)	(41,024)
Шуудан холбооны зардал	(24,782)	(4,834)
Тээврийн зардал	(24,789)	(362)
Түрээсийн зардал	(23,401)	(230,978)
Хангамжийн зардал	(13,899)	(4,018)
Нийгмийн халамж, тэтгэмжийн зардал	(13,642)	(8,542)
Шагнал урамшууллын зардал	(10,224)	(2,100)
Бусад зардал	(38,855)	(42,844)
	(3,514,222)	**(1,941,550)**

Борлуулалт, маркетингийн зардал

	2025 ₮'000	2024 ₮'000
Ажилчдын цалингийн зардал	(879,534)	(407,416)
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	(109,881)	(50,347)
Маркетинг идэвхжүүлэлтийн зардал	(475,011)	(285,952)
Бусад зардал	(1,145)	(61,848)
	(1,465,571)	**(805,563)**

9. Санхүүгийн орлого ба зардал

	2025 ₮'000	2024 ₮'000
Санхүүгийн орлого		
Бонд, итгэлцэл, ХБҮЦ-ны хүүгийн орлого (Тод.15)	285,686	188,287
Харилцахын үлдэгдэлд тооцож олгосон хүүгийн орлого (Тод.11)	138,883	183,697
Хадгаламжийн хүүгийн орлого (Тод.11 ба 15)	1,587,941	1,219,514
Ажилчдад олгосон зээлийн хүүгийн орлого (Тод.14)	7,073	16,692
Нийт санхүүгийн орлого	***2,019,583***	***1,608,190***
Санхүүгийн зардал		
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал (Тод.19)	(141,249)	(1,703)
Нийт санхүүгийн зардал	***(141,249)***	***(1,703)***
Цэвэр санхүүгийн орлого	***1,878,334***	***1,606,487***

10. Орлогын татварын зардал

Группийн компаниуд нь тайлант жилүүдэд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулийн дагуу нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын 6 тэрбум төгрөг хүртэлх дүнд 10 хувийн орлогын албан татвар, түүнээс дээш дүнд 25 хувийн орлогын албан татвар ногдуулж, ногдол ашгийн орлого, хүүгийн орлого, хувьцаа борлуулсны орлогод тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулж, тайлагнасан.

Дээрх татварыг охин компаниудын тусдаа санхүүгийн тайлангаарх орлого, ашигт үндэслэн ногдуулсан.

Тайлант жилүүдийн татварын зардлыг харуулбал:

	2025 ₮'000	2024 ₮'000
Тайлант үеийн татварын зардал		
Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татвар	2,395,302	1,412,724
Тусгай хувь хэмжээгээр ногдуулсан татвар	349,362	1,477,440
Хасах нь: Татварын хөнгөлөлт	(285,846)	-
Хасах нь: Татварын хөнгөлөлт	(127,342)	-
Нийт тайлант үеийн татварын зардал	***2,331,476***	***2,890,164***
Хойшлогдсон татварын зардал (өгөөж)		
Тайлант үед үүссэн болон хэрэгжсэн түр зөрүүний хойшлогдсон татвар	(376,545)	130,288
Нийт татварын зардал	***1,954,931***	***3,020,452***

Татварын хөнгөлөлт

- Групп нь тайлант онд 299,287 мянган төгрөгийг хандивт зарцуулснаас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д заасан нөхцөл шаардлагыг хангасан хандивын зардлын дүнтэй тэнцэх хэмжээний буюу 285,846 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт тооцож, тайлант үеийн нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татварыг бууруулж тайлагнасан байна. (Тод.8)
- Мөн охин компани өөрийн эзэмшиж байсан толгой компанийн хувьцааг арилжсан орлогоос хуулийн шаардлага хангасан зардал (хувьцааг худалдан авсан үнэ, холбогдох зардал)-ыг хасаж, тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулсан. Нээлттэй зах зээлд хувьцаа арилжсан орлогоос Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.17-д заасан "дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар хөнгөлөх" тухай заалтын дагуу ногдуулсан татварыг 90 хувь буюу 127,342 мянган төгрөгөөр бууруулж, хөнгөлөлт тооцож тайлагнасан байна.

10. Орлогын татварын зардал (Үргэлжлэл)

Орлогын татварын авлага (өр төлбөр)-ийн үлдэгдлийг харуулбал:

	2025 ₮'000	2024 ₮'000
Орлогын албан татварын авлага (өглөг)		
01 сарын 01	(392,494)	(223,656)
Төлбөл зохих татвар	(2,331,476)	(2,890,164)
Татварын тохируулга	-	(7,153)
Төлсөн	2,986,951	2,728,479
12 сарын 31	**262,979**	**(392,494)**

Хойшлогдсон татварын үлдэгдэл

2025.12.31	**ХТХ ₮'000**	**ХТӨ ₮'000**	**Ашиг алдагдалд ₮'000**
Ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз гарзтай холбоотой	345	373	(1,113)
Биет ба биет бус хөрөнгө	-	97,344	44,033
Дансны болон бусад авлага	3	-	(11)
Урьдчилж төлсөн тооцоо	-	26,435	9,319
Гэрээний өр төлбөр	1182	-	(1,182)
Дансны өглөг	427,591	-	(427,591)
Нийт хойшлогдсон татварын өгөөж			***(376,545)***
Нийт хойшлогдсон татварын үлдэгдэл	***429,121***	***124,152***	
Цэвэршүүлсэн дүн	*(124,152)*		
Цэвэр хойшлогдсон татвар	***304,969***	**-**	

2024.12.31	**ХТХ ₮'000**	**ХТӨ ₮'000**	**Ашиг алдагдалд ₮'000**
Ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз гарзтай холбоотой	-	1,141	1,105
Биет ба биет бус хөрөнгө	-	53,311	53,215
Дансны авлага	-	8	(1,200)
Урьдчилж төлсөн тооцоо	-	17,116	11,213
Дансны өглөг	-	-	65,955
Нийт хойшлогдсон татварын зардал			***130,288***
Нийт хойшлогдсон татварын үлдэгдэл	**-**	**71,576**	
Цэвэршүүлсэн дүн		**-**	
Цэвэр хойшлогдсон татвар	**-**	**71,576**	

10. Орлогын татварын зардал (Үргэлжлэл)

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлуулсан татварын нийлбэрээс бүрдэнэ. Одоогийн болон хойшлогдсон татвар нь бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл өмчөөр хүлээн зөвшөөрөгдөх зүйлстэй хамааралтайгаас бусад тохиолдолд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөнө. Эдгээр зүйлстэй холбоотой татвар нь бусад дэлгэрэнгүй орлогоор эсвэл өмчөөр хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох тайлангийн өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон дүн болон өмнөх жилүүдийн татварт хийсэн тохируулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын үлдэгдлийг санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ ба тэдгээрийн татварын зорилгоорх дүн хоорондын түр зөрүүг тооцоолох замаар тодорхойлдог. Хойшлогдсон татварын дүнг тайлагналын өдрөөрх болон хойшлогдсон татварыг хэрэгжих үед хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр хүлээгдэж байгаа татварын дундаж хувиар тооцдог.

Ашиглагдаагүй татварын алдагдлыг ашиглаж чадахуйц ирээдүйн татвар ногдох ашигтай байх нэлээд их магадлалтай тохиолдолд тэрхүү ашиглаж болох хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Энэ төсөөллийг тайлант үе бүрд хянадаг. Тухайн хойшлогдсон татварын хөрөнгийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдох ашиг ирээдүйд олох магадлалгүй болсон тохиолдолд тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна.

Групп нь санхүүгийн байдлын тайлан дахь хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг суутган тооцох буюу цэвэр дүнгээр илэрхийлэх хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй, цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг хэрэгжүүлэх ба өр төлбөрийг барагдуулах ажиллагааг нэгэн зэрэг хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд л хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийн цэвэр дүнг гаргана.

11. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Бэлэн мөнгө	-	583
Арилжааны банк дахь төгрөгийн харилцах	7,487,070	5,077,534
Арилжааны банк дахь валютын харилцах	88,987	62,753
Арилжааны банк дахь төгрөгийн хадгаламж	16,531,884	8,585,840
Арилжааны банк дахь валютын хадгаламж	-	926,888
Санхүүгийн байдлын тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	***24,107,941***	***14,653,598***

Арилжааны банкнууд дахь харилцах дансны үлдэгдэлд хүү тооцогддог ба тайлант жилүүдэд 138,883 (2024: 183,697) мянган төгрөгийн хүүгийн орлого хүлээн авсан.

Дотоодын арилжааны банк дахь төгрөгийн болон валютын уян хадгаламжаас 1,587,941 (2024: 1,219,514) мянган төгрөгийн хүүгийн орлого хүлээн зөвшөөрсөн. (Тод.9)

11. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (Үргэлжлэл)

Эдгээр хадгаламжууд нь гэрээний хугацаанд сар бүрийн эцэст эсвэл 3 сард нэг удаа зарлага гаргах эрхтэй бөгөөд заавал байлгах доод үлдэгдэл нь 1,000 мянган төгрөг.

2024 болон 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх арилжааны банк дахь төгрөгийн болон валютын хадгаламжийн хугацаа, хүүгийн түвшинг дэлгэрэнгүй харуулбал:

	2025.12.31 ₮'000	Хүүгийн түвшин /жилээр/	Эхэлсэн хугацаа	Дуусах хугацаа
Арилжааны банк дахь төгрөгийн хадгаламж				
М банк	638,000	7%	10/2/2025	10/2/2026
М банк	11,000,000	13.8-14%	12/16/2025	3/31/2026
Тээвэр хөгжлийн банк	2,000,000	18%	12/26/2024	12/26/2025
ХААН банк	2,761,118	16%	9/10/2025	9/9/2026
ХААН банк	132,766	7.2%	7/14/2025	1/14/2026
Төгрөгийн хадгаламж	*16,531,884*			
Арилжааны банк дахь валютын хадгаламж				
Тээвэр хөгжлийн банк	981,638	5.5%	4/7/2025	4/07/2027
Валютын хадгаламж	*981,638*			
Нийт хадгаламж	**17,513,522**			
Үүнээс:				
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөөр толилуулсан	16,531,884			
Бусад санхүүгийн хөрөнгөөр толиуулсан	981,638			

	2024.12.31 ₮'000	Хүүгийн түвшин /жилээр/	Эхэлсэн хугацаа	Дуусах хугацаа
Арилжааны банк дахь төгрөгийн хадгаламж				
М банк	1,000,000	11.50%	12/30/2024	1/30/2025
Тээвэр хөгжлийн банк	2,000,000	18.0%	12/26/2024	12/25/2025
ХААН банк	13,405	12.5%	4/18/2024	7/6/2024
ХААН банк	2,500,000	7.2-15.0%	6/14/2024	6/13/2025
ХААН банк	172,435	7.2-10%	7/9/2024	7/9/2025
Худалдаа хөгжлийн банк	2,900,000	15.5%	12/30/2024	12/30/2025
Төгрөгийн хадгаламж	*8,585,840*			
Арилжааны банк дахь валютын хадгаламж				
М банк	926,888	3.7%	7/30/2024	1/30/2025
Валютын хадгаламж	*926,888*			
Нийт хадгаламж	**9,512,728**		-	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөөр толилуулсан	9,512,728			

11. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (Үргэлжлэл)

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Мөнгөн хөрөнгө нь гар дээрх бэлэн мөнгө, банк дахь харилцах данс болон хугацаагүй хадгаламжаас бүрддэг. Богино хугацаат хадгаламж нь хэрвээ тодорхой дүнгээр мөнгө рүү шууд хөрвөх боломжтой, 3 сар ба түүнээс богино хугацаатай, үнэ цэний өөрчлөлтийн эрсдэлд өртөмтгий байдал маш бага байвал мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө гэж үзнэ.

12. Бараа материал

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Хангамжийн материал	3,793	2,737
Нийт бараа материал	***3,793***	***2,737***

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнэ цэний аль багаар хэмжинэ.

Бараа материалын өртөг нь худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбоотой гарсан бусад зардлаас бүрддэг. Цэвэр боломжит үнэ цэнэ (ЦБҮЦ) нь тооцоолсон борлуулалтын үнээс тооцоолсон гүйцээх зардал болон гарахаар тооцоолсон борлуулалт маркетингийн зардлыг хассан дүн юм.

13. Урьдчилгаа

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Урьдчилж төлсөн лицензийн төлбөр	32,740	6,710
Урьдчилж гарсан зардлууд	100,912	108,115
Нийт урьдчилгаа	***133,652***	***114,825***

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Урьдчилж төлсөн төлбөрүүд нь ирээдүйд худалдан авах бараа үйлчилгээ эсвэл хөрөнгөд урьдчилан бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн төлбөр юм.

Төлсөн төлбөрүүдийг хуримтлуулан санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгө хэсэгт тайлагнана.

14. Худалдааны болон бусад авлага

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Дансны авлага	2,724,794	2,523,731
Барьцааны авлага	89,308	14,305
Хүүгийн авлага	271,798	280,457
Бусад татвар, НДШ-ийн авлага	9,916	2,019
Ажиллагсдаас авах болон бусад авлага	88,487	268,796
Хасах нь: Хүлээгдэж буй зээлийн алдагдлын сан (Тод.25)	(82,812)	(79,068)
Нийт худалдааны болон бусад авлага	***3,101,491***	***3,010,240***

14. Худалдааны болон бусад авлага (Үргэлжлэл)

Харилцагчтай байгуулсан гэрээнээс үүссэн худалдааны авлага нь 30-90 хоногийн дотор төлөгдөх нөхцөлтэй байдаг ба энэ нь ихэвчлэн дараа тооцоо нөхцөлтэй харилцагчдаас авах шимтгэлийн авлага байдаг.

Худалдааны авлага нь ихэвчлэн богино хугацаатай байдаг учраас дансны үнэ нь бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байдаг.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Томоохон санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй худалдааны авлагыг анх үүсэх үед нь ажил гүйлгээний үнээр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх авлагыг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрдөг ба энэ нь ерөнхийдөө ажил гүйлгээний үнээс ажил гүйлгээтэй холбоотой аливаа зардлыг хассан дүнтэй тэнцүү байдаг.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед, гэрээний мөнгөн урсгал болох зөвхөн хүү ба үндсэн төлбөрийг цуглуулах зорилгоор эзэмшиж буй худалдааны болон бусад авлагыг хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцож, санхүүгийн орлогоор ашиг алдагдалд бүртгэдэг. Үнэ цэний бууралтыг ашиг алдагдалд тусдаа мөр болгож толилуулдаг.

Худалдааны болон бусад авлагыг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө.

- Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дуусвар болсон, эсвэл
- Мөнгөн урсгалын эрхийг дараах байдлаар шилжүүлсэн:
  - Эзэмшлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн; эсвэл
  - Компани эзэмшлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй, шилжүүлээгүй, мөн санхүүгийн хөрөнгийн хяналтыг хадгалж авч үлдээгүй,
- Компани нь худалдааны болон бусад авлагыг бусдад шилжүүлэх боловч уг хөрөнгийн бүх эсвэл дийлэнх эрсдэл ба өгөөжийг хадгалсан хэвээр байх гүйлгээнд оролцсон үед тэдгээр санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.

15. Бусад санхүүгийн хөрөнгө

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Хугацаатай хадгаламж (Тод.11)	981,638	-
Итгэлцэл	1,000,000	-
Бусад өрийн хэрэглүүр	100,00	200,000
Бирж дээр бүртгэгдсэн өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	744,832	744,832
Нийт бусад санхүүгийн хөрөнгө	**2,826,470**	**944,832**

Итгэлцэл - Охин компани болох ККТТ ХХК нь Жи Эс Би Капитал ББСБ ХХК-д жилийн 20%-ийн өгөөжтэй, 12 сарын хугацаатай, хүүг хугацааны эцэст төлөх нөхцөлтэй 1,000,000 мянган төгрөгийн итгэлцлийг 2025 оны 02 сарын 20-нд байршуулсан байна.

Өмчийн хэрэглүүр - Бирж дээр бүртгэгдсэн өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаар ККТТ ХХК-ийн эзэмшиж буй Голомт банк ХК-д оруулсан 573,282 ширхэг 744,832 мянган төгрөгийн өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг бүртгэж толилуулсан байна.

15. Бусад санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

2023 оны 12 сарын 12-ны өдрийн Инвескор Капитал ҮЦК ХХК-тай хийсэн хувьцаа худалдан авах гэрээний дагуу худалдагч тал 6 сарын дараа адил нөхцөлөөр эргүүлэн худалдан авах үүрэгтэй бөгөөд уг гэрээний хэрэгжилт хүлээгдэж байна. Тайлант жилүүдэд бирж дээр бүртгэгдсэн өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаас 57,328 (2024: 69,105) мянган төгрөгийн ногдол ашиг хүлээн авсан байна. (Тод.7)

Бусад өрийн хэрэглүүр - Охин компани болох Дижитал мерчант сервисэс ХХК нь 2024 оны 8 сард Ийзи Инвестмент Ассуранс ХХК-д сарын 2 хувийн хүүтэй, өгөөжийг хугацааны эцэст хүртэх нөхцөлтэй, 6 сарын хугацаатай, 200,000 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Талууд 2025 оны 02 сард 100,000 төгрөгийн хөрөнгө оруулалтын хугацааг 12 сараар сунгасан ба гэрээний бусад нөхцөлд өөрчлөлт орооогүй.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг зөвхөн тэдгээрийг цэвэр дүнгээр хаах эсвэл нэгэн зэрэг барагдуулах хууль ёсны эрхтэй тохиолдолд хооронд нь хааж Санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр харуулна. Тайлагналын өдрөөр Группэд цэвэршүүлж хаасан санхүүгийн хөрөнгө, өр төлбөр байгаагүй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бусад санхүүгийн хөрөнгүүдийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба энэ нь ихэвчлэн тэдгээрийн ажил гүйлгээний үнэтэй тэнцүү байдаг. Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгүүдийн хувьд ажил гүйлгээний үнийг тэдгээрийн дансны үнэ рүү тохируулдаг.

Ашиг алдагдлаарх БҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгүүд

Төлбөр нь зөвхөн хүү болон үндсэн төлбөр биш санхүүгийн хөрөнгө буюу үүнд, өмчийн хэрэглүүр болон деривативуудыг ашиг алдагдлаарх БҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөнд ангилж, БҮЦ-ийн бүх өөрчлөлтүүдийг санхүүгийн орлого, зардлаар толилуулна.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүд

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед, гэрээний мөнгөн урсгал болох зөвхөн хүү ба үндсэн төлбөрийг цуглуулах зорилгоор эзэмшиж буй өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцож, санхүүгийн орлогоор ашиг алдагдалд бүртгэдэг. Үнэ цэний бууралтыг ашиг алдагдалд тусдаа мөр болгож толилуулдаг.

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

- Санхүүгийн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах гэрээний эрх дуусвар болсон, эсвэл
- Хөрөнгийг дараах байдлаар шилжүүлсэн:
  - Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн; эсвэл
  - Групп нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдээгүй ба санхүүгийн хөрөнгийн хяналтыг ч мөн өөртөө хадгалан үлдэхгүйгээр шилжүүлсэн

16. Урт хугацаат хөрөнгө оруулалт

	2025	2024
	₮'000	₮'000
01 сарын 01	**1,250,000**	**-**
Нэмэгдсэн	169,400	1,500,000
Хасагдсан	(750,000)	(250,000)
12 сарын 31	**669,400**	**1,250,000**

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг охин компани болох ККТТ ХХК эзэмшдэг.

Үүнд:

- Компани 2024 оны 04 сарын 05-ны өдөр Бичил Эй Би Эс Лояалти ТЗК ХХК-ийн 24 сарын хугацаатай, 19 хувийн өгөөжтэй 1,000,000 мянган төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авсан ба тайлант онуудад 750,000 мянган төгрөгийн үндсэн төлбөрийг хүлээн авч тайлант хугацааны эцэст 250,000 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Мөн 2024 оны 08 сарын 23-ны өдөр Инвескор капитал УЦК ХХК-ийн 18 сарын хугацаатай, 17 хувийн өгөөжтэй, 500,000 мянган төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авсан ба тайлант онд үндсэн төлбөрөөс 250,000 мянган төгрөг хүлээн авч тайлант үеийн эцэст 250,000 мянган төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны үлдэгдэлтэй байна.
- Тайлант онд Бид ББСБ ХХК-ийн гаргасан 24 сарын хугацаатай, 18 хувийн өгөөжтэй, хүүг улирал тутам төлөх нөхцөлтэй 1,694 ширхэг, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй бондод хөрөнгө оруулсан байна.

Тайлант жилүүдэд эдгээр хөрөнгө оруулалтаас 171,325 (2024: 147,017) мянган төгрөгийн хүүгийн орлого хүлээн зөвшөөрсөн.

17. Үндсэн хөрөнгө

	Машин, тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Түрээсийн сайжруулалт	Нийт
	₮'000	₮'000	₮'000	₮'000	₮'000
Өртөг					
2024.01.01	97,000	61,339	774,408	-	**932,747**
Худалдан авсан		26,155	885,308	-	**911,463**
Данснаас хассан		(9,329)	(22,221)	-	**(31,550)**
2024.12.31	**97,000**	**78,165**	**1,637,495**	-	**1,812,660**
Худалдан авсан		115,895	409,427	256,855	**782,177**
Данснаас хассан		(17,063)	(7,076)	-	**(24,139)**
2025.12.31	**97,000**	**176,997**	**2,039,846**	**256,855**	**2,570,698**
Хуримтлагдсан элэгдэл					
2024.01.01	28,861	15,804	303,784	-	**348,449**
Элэгдэл	9,721	7,706	245,113	-	**262,540**
Данснаас хассан		(5,707)	(21,793)	-	**(27,500)**
2024.12.31	**38,582**	**17,803**	**527,104**	-	**583,489**
Элэгдэл	9,695	14,601	417,406	-	**441,702**
Данснаас хассан		(6,216)	(6,902)	-	**(13,118)**
2025.12.31	**48,277**	**26,188**	**937,608**	-	**1,012,073**
Цэвэр дансны үнэ					
2024.12.31	**58,418**	**60,362**	**1,110,391**	-	**1,229,171**
2025.12.31	**48,723**	**150,809**	**1,102,238**	**256,855**	**1,558,625**

17. Үндсэн хөрөнгө (Үргэлжлэл)

Тайлант хугацаанд түрээсэлж буй хөрөнгөтэй холбоотойгоор 256,855 мянган төгрөгийн засварын зардал гарсныг түрээсийн сайжруулалт дансанд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Түрээсийн сайжруулалтыг түрээсийн гэрээний хугацаанд элэгдүүлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бүх үндсэн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед капиталжуулсан зээлийн хүүгийн зардлыг багтаасан өртгөөр нь бүртгэдэг.

Үндсэн хөрөнгийн зүйлийн томоохон хэсэг нь өөр ашиглалтын хугацаатай бол тэдгээрийг тусдаа хөрөнгөөр бүртгэдэг.

Дараа үеийн зардлыг үүнээс үндсэн хөрөнгийн зүйлийн эд ангийг солих, засварлах нь Группэд ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг авчрах магадлалтай тохиолдолд л тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Бусад бүх засвар, үйлчилгээний зардал, дараа үеийн зардлыг тэдгээр зардал гарсан тайлант үеийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэний бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнана.

Хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн түүний өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс холбогдох үлдэх өртгийг хассан дүнг тэдгээрийн тооцоолсон ашиглалтын хугацаанд шулуун шугамын арга ашиглан дараах сууриар элэгдүүлдэг:

- Машин тоног төхөөрөмж 10 жил
- Тавилга эд хогшил 10 жил
- Компьютер, бусад хэрэгсэл 2 жил

Элэгдүүлэх түвшин, ашиглалтын хугацаа болон үлдэх өртгийг тайлант үе бүрийн эцэст эргэн хянадаг ба шаардлагатай тохиолдолд залруулдаг. Тайлант хугацаанд тооцоолсон ашиглалтын хугацаанд өөрчлөлт орооогүй.

Групп нь үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнэд үнэ цэний бууралтын аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл тухайн хөрөнгийн хувьд дангаар нь эсвэл тусдаа мөнгөн гүйлгээ бий болгодоггүй бол тухайн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнэ цэний бууралтыг үнэлж тооцно.

18. Биет бус хөрөнгө

	Программ хангамж	Зохиогчийн эрх	Тусгай зөвшөөрөл	Барааны тэмдэг	Бусад биет бус хөрөнгө	Нийт
	₮'000	₮'000	₮'000	₮'000	₮'000	₮'000
Өртөг						
2024.01.01	167,865	24,091	20,000	-	31,763	**243,719**
Худалдан авсан	90,909	-	-	16,667	218,850	**326,426**
2024.12.31	**258,774**	**24,091**	**20,000**	**16,667**	**250,613**	**570,145**
Худалдан авсан	22,029	-	6,000	-	-	**28,029**
Данснаас хассан	-	-	(20,000)	-	-	**(20,000)**
2025.12.31	**280,803**	**24,091**	**6,000**	**16,667**	**250,613**	**578,174**
Хуримтлагдсан хорогдол						
2024.01.01	812	-	16,250	-	10,588	**27,650**
Хорогдол	4,169	-	2,505	845	29,003	**36,522**
2024.12.31	**4,981**	**-**	**18,755**	**845**	**39,591**	**64,172**
Хорогдол	36,035	-	1,495	8,333	83,509	**129,372**
Данснаас хассан	-	-	(20,000)	-	-	**(20,000)**
2025.12.31	**41,016**	**-**	**250**	**9,178**	**123,100**	**173,544**
Цэвэр дансны үнэ						
2024.12.31	**253,793**	**24,091**	**1,245**	**15,822**	**211,022**	**505,973**
2025.12.31	**239,787**	**24,091**	**5,750**	**7,489**	**127,513**	**404,630**

18. Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)

Программ хангамж нь группийн хэмжээнд ашиглаж буй санхүүгийн программ, хүний нөөцийн программ хангамжууд юм.

Тусгай зөвшөөрөл нь Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн тушаалын дагуу охин компани болох ККТТ ХХК-ийн нэр дээр "Аутсорсингийн үйлчилгээ авах" тусгай зөвшөөрөл болон Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А-245 тоот тушаалын дагуу "Мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх" тусгай зөвшөөрлийг олж авахтай холбоотой зардлуудыг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Зохиогчийн эрх нь Монгол улсын Оюуны өмчийн газар бүртгэлтэй QR кодоор мэдээлэл солилцох программын зохиогчийн эрх, КюПэй (QPay) аппликэйшн бөгөөд охин компани ККТТ ХХК эзэмшдэг.

Барааны тэмдэг нь QPay брэндийн лого, брэнд бүүк буюу өөрийн үйлчилгээг бусдаас ялгагдах зорилгоор бүтээсэн илэрхийлэмж бөгөөд Оюуны өмчийн газарт бүртгүүлснээр 10 жилийн хугацаанд барааны тэмдэг эзэмшигчийн бүртгэл баталгааждаг.

Бусад биет бус хөрөнгөнд сервер, компьютерын программ хангамжийн багц багтсан.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бүх биет бус хөрөнгийг өртгөөр нь хэмжинэ. Биет бус хөрөнгийн өртгийг түүний ашиглалтын хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна. Ашиглалтын хугацаа тодорхойгүй бол хорогдуулахгүй.

Биет бус хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа дараах байдалтай байна.

- Программ хангамж ашиглах эрх — 2-3 жил
- Зохиогчийн эрх — Хугацаагүй
- Тусгай зөвшөөрөл — 4 жил
- Барааны тэмдэг — 10 жил
- Бусад биет бус хөрөнгө — Хүчин төгөлдөр байх хугацаанд

Хорогдуулах түвшин болон ашиглалтын хугацааг үндэслэлтэй эсэхийг тайлант үе бүрийн эцэст дахин хянадаг. Тайлант хугацаанд тооцсон ашиглалтын хугацаанд өөрчлөлт ороогүй. Ашиглалтын хугацаа нь Группэд хуримтлагдан бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн тайлант үеийн эцсээрх хамгийн сайн тооцооллыг илэрхийлж байдаг. Бусад төсөөлөл таамаглалуудыг хэрэглэх нь хүлээн авахаар хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн тооцоолсон хугацааг өөрчлөхөд хүргэж болно.

Биет бус хөрөнгийг данснаас хассанаас үүссэн олз гарзыг тухайн хөрөнгийн дансны үнэ болон хүлээн авсан зүйлсийн зөрүүгээр хэмжиж, хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэний бууралт

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгөнд үнэ цэний бууралтын шинж тэмдэг илэрвэл үнэ цэний бууралтын тест хийх шаардлагатай. Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд үнэ цэний бууралт үүссэн эсэхийг жил бүр үнэлнэ.

18. Биет бус хөрөнгө (Үргэлжлэл)

Үнэ цэний бууралтыг илтгэх шинж тэмдгүүд байвал үнэ цэний бууралтын гарзын дүнг тодорхойлохын тулд хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно. Хэрэв тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлох боломжгүй байвал тухайн хөрөнгийн харьяалагдаж байгаа мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг тооцно.

Мөнгө үүсгэгч нэгж гэж бие даасан орох мөнгөн урсгалыг үүсгэгч хөрөнгүүдийн хамгийн бага бүрдэл юм.

Хэрэв хөрөнгийн эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүн нь дансны үнээсээ бага байхаар болсон бол дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл бууруулна. Тухайн хөрөнгө нь дахин үнэлэгдсэн дүнгээр хэмжигдсэнээс бусад тохиолдолд үнэ цэний бууралтын гарзыг тэр даруйд нь зардлаар хүлээн зөвшөөрнө. Харин дахин үнэлэгдсэн хөрөнгийн хувьд үнэ цэний бууралтын гарзыг дахин үнэлгээний бууралт байдлаар бүртгэнэ.

Дараагийн тайлант үеүдэд үнэ цэний бууралтын буцаалт үүсэж болно. Хэрэв буцаалт үүсвэл хөрөнгийн нэмэгдсэн дансны үнэ нь хэрэв өмнө нь үнэ цэний бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнээс хэтрэх ёсгүй.

19. Түрээс (түрээслэгчээр)

Групп нь 636.26 мкв оффисын зориулалттай талбай түрээсэлсэн.

Түрээс нь ерөнхийдөө 3 жилийн хугацаатай ба гэрээг сунгах сонголт агуулсан. Удирдлага түрээсийн гэрээний сунгах сонголтыг хэрэгжүүлэх магадлалыг үнэлж үзээд түрээсийн өр төлбөр, ашиглах эрхтэй хөрөнгийн тооцоололд түрээсийн хугацааг 3 жилээр тооцсон. Уг төсөөлөл таамаглалын ул үндэслэлтэй байдлыг жил бүр үнэлнэ.

Түрээслэгчийн өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн түвшинг 16.6 хувь гэж тооцсон.

Бүх түрээсийн хувьд Групп түрээсэлсэн хөрөнгөө бусдад давхар түрээслүүлэхийг хориглосон. Түрээслүүлэгчид түрээсийн 2 сарын төлбөртэй тэнцэх барьцааг байршуулсан бөгөөд холбогдох түрээсийн хөрөнгийг өөр бусад зээлд барьцаалах боломжгүй.

Санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн дүн

Ашиглах эрхтэй хөрөнгө	Оффис	Бусад байр	Нийт
	₮'000	₮'000	₮'000
Өртөг			
2024.01.01	247,583	85,909	333,492
Нэмэгдсэн	-	34,247	34,247
Хасагдсан	(247,583)	(120,156)	(367,739)
2024.12.31	-	-	-
Нэмэгдсэн	1,145,409	-	1,145,409
2025.12.31	**1,145,409**	**-**	**1,145,409**

19. Түрээс (түрээслэгчээр) (Үргэлжлэл)

	Оффис	Бусад байр	Нийт
	₮'000	₮'000	₮'000
Хуримтлагдсан элэгдэл			
2024.01.01	231,110	62,608	293,718
Нэмэгдсэн	16,473	19,160	35,633
Хасагдсан	(247,583)	(81,768)	(329,351)
2024.12.31	-	-	-
Нэмэгдсэн	319,795	-	319,795
2025.12.31	**319,795**	-	**319,795**
Цэвэр дансны үнэ			
2024.12.31	-	-	-
2025.12.31	**825,614**	-	**825,614**

Түрээсийн өр төлбөр	**2025.12.31**	**2024.12.31**
	₮000	**₮000**
Түрээсийн өр төлбөр – эргэлтийн	368,112	-
Түрээсийн өр төлбөр - эргэлтийн бус	504,977	-
	873,089	-

Орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн

Групп түрээстэй холбоотойгоор дараах дүнгүүдийг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн байна.

	2025	2024
	₮'000	₮'000
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	319,795	53,407
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал (Тод.9)	141,249	1,703
Богино хугацаат түрээстэй холбоотой зардлууд (удирдлагын зардалд багтсан)	23,401	230,978

Мөн Групп нь богино хугацаат буюу 12 сараас богино хугацаат түрээсийн гэрээтэй ба түрээсийн хөрөнгө нь бага үнэ цэнтэй дата центр байна. Компани нь эдгээр хөрөнгийн түрээсийн хувьд түрээсийн өр төлбөр, ашиглах эрхтэй хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй, харин оронд нь түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар зардалд хүлээн зөвшөөрөх аргыг сонгосон.

Гэрээг сунгах эсэх сонголт

Түрээс нь Группийн хүсэлтээр түрээсийн хугацааг сунгах сонголт агуулсан. Түрээсийн эхлэлийн өдөр Групп энэхүү гэрээ сунгах зааltыг ирээдүйд бодитоор хэрэгжүүлэх үндэслэлтэй эсэхийг тодорхойлохдоо томоохон мэргэжлийн үнэлэмж хийсэн бөгөөд гэрээг сунгах сонголтыг хэрэгжүүлнэ гэсэн ул үндэслэлтэй төсөөлөл байхгүй нөхцөл байдалд томоохон өөрчлөлт орсон тохиолдолд энэхүү үнэлгээгээ шинэчилдэг.

19. Түрээс (түрээслэгчээр) (Үргэлжлэл)

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Түрээслэгчийн хувьд Групп түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг аль алиныг нь агуулсан гэрээнүүдтэй. Компани нь гэрээнд тусгагдсан төлбөрийг түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийн харгалзах бие даасан үнэд үндэслэж хуваарилдаг.

Түрээсэлсэн хөрөнгийг Групп ашиглах боломжтой болсон өдөр Групп нь ашиглах эрхтэй хөрөнгө болон түүнд хамаарах түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн өр төлбөр

Түрээсийн өр төлбөрийг анх түрээсийн эхлэлийн өдрөөрх түрээсийн төлбөрүүдийн цэвэр өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ. Энэ нь түрээсийн хугацааны туршид тухайн суурь хөрөнгийн ашиглах эрхэд хамаарах дараах төлбөрүүдээс бүрдэнэ.

- Тогтмол төлбөрөөс (үүнд, мөн чанарын хувьд тогтмол төлбөрүүдээс) түрээсийн аливаа урамшууллын авлагыг хассан дүн;
- Эхлэлийн өдөр индекс буюу хувь хэмжээг ашигласнаар анх хэмжсэн, индекс буюу хувь хэмжээнээс хамаардаг, түрээсийн хувьсах төлбөр;
- Үлдэх өртгийн баталгааны дагуу түрээслэгчийн төлөхөөр хүлээгдэж буй дүн;
- Худалдан авах сонголтоо түрээслэгч хэрэгжүүлэх нь үл үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх үнэ; болон
- Түрээсийг цуцлах сонголтоо түрээслэгч хэрэгжүүлэх талаар тухайн түрээсийн нөхцөлд тусгадаг бол түрээсийг цуцалсны улмаас төлөх торгуулийн дүн.

Түрээсийн хугацаа гэдгийг дараах 2 хугацааны хамтаар түрээсийн үл цуцлагдах хугацаа гэж тодорхойлно:

a) Түрээсийг сунгах сонголтоо түрээслэгч хэрэгжүүлэх нь үл үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтод хамаарах хугацаа

b) Түрээсийг цуцлах сонголтоо түрээслэгч хэрэгжүүлэхгүй гэдэг нь үл үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтод хамаарах хугацаа

Индекс буюу хувь хэмжээнд үндэслээгүй хувьсах түрээсийн төлбөрүүдийг тэдгээрийн гарсан холбогдох тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн төлбөрүүдийг түрээсийн нуугдмал хүүгийн түвшинг ашиглан дискаунтчилна. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшинг шууд тодорхойлох боломжгүй бол түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшинг ашиглана.

Түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшин гэдэг нь түрээслэгч тухайн ашиглах эрхтэй хөрөнгөтэй ижил үнэ цэнтэй хөрөнгийг эдийн засгийн ижил төсөөтэй орчинд олж авахад шаардлагатай мөнгө, санг ижил төсөөтэй хугацаа ба баталгаатайгаар зээлдэн авахын тулд төлөх байсан хүүгийн хувь хэмжээ юм.

Түрээсийн өр төлбөрийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хүлээгдэж буй түрээсийн хугацаа, индекс буюу хувь хэмжээтэй холбоотой түрээсийн төлбөр эсвэл худалдан авах сонголтын талаарх төсөөлөлд өөрчлөлт орвол түрээсийн өр төлбөрийг дахин хэмжинэ.

19. Түрээс (түрээслэгчээр) (Үргэлжлэл)

Ашиглах эрхтэй хөрөнгө

Ашиглах эрхтэй хөрөнгийг дараахаас бүрдсэн өртгөөр хэмжинэ:

- Түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилтийн дүн;
- Түрээсийн эхлэлийн өдөр эсвэл түүнээс өмнө төлсөн аливаа түрээсийн төлбөрүүдээс аливаа хүлээн авсан түрээсийн урамшууллыг хассан дүн;
- Түрээслэгчийн гаргасан аливаа анхны шууд зардал; болон
- Тухайн суурь хөрөнгийг буулгаж нураах, зайлуулах, талбайг цэвэрлэх, сэргээхтэй холбоотойгоор түрээслэгчийн гаргах өртөг, зардлын тооцоолсон дүн.

Ашиглах эрхтэй хөрөнгийг ерөнхийдөө тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богинод нь шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Хэрэв Групп худалдан авах сонголтыг хэрэгжүүлэх магадлал өндөр байгаа бол ашиглах эрхтэй хөрөнгийг түүний ашиглалтын хугацаанд нь элэгдүүлнэ.

Ашиглах эрхтэй хөрөнгөнд мөн үнэ цэний бууралт үүсэж болно.

Богино хугацаатай, суурь хөрөнгө нь бага үнэ цэнтэй түрээс

Групп нь мөн богино хугацаат түрээстэй ба 12 сараас бага хугацаатай эсвэл Групп нь бага үнэ цэнтэй гэж үнэлсэн тоног төхөөрөмж, хөрөнгүүдийн түрээс байдаг.

Ийм дүнгүүдийн хувьд Групп ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй, харин түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар зардалд хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн.

20. Худалдааны болон бусад өр төлбөр

	2025.12.31	2024.12.31
	₮'000	₮'000
Худалдааны өглөг	2,231,556	1,361,785
Нийт худалдааны өглөг	**2,231,556**	**1,361,785**
Цалингийн өглөг	107,940	47,166
Татвар, шимтгэлийн өглөг	4,223	859,538
Ажилчдад өгөх өглөг	912	1,118
Нийт бусад өр төлбөр	**113,075**	**907,822**
Нийт худалдааны болон бусад өглөг	**2,344,631**	**2,269,607**

Бүх худалдааны өглөгүүд нь Группийн ердийн үйл ажиллагааны цикл дотор буюу 1 жилийн дотор төлөгдөхөөр байгаа тул эргэлтийн өр төлбөрөөр ангилагдсан.

Худалдааны өглөг нь ерөнхийдөө богино хугацаатай байдаг тул тэдгээрийн дансны үнэ нь БҮЦ-тэйгээ ойролцоо байдаг.

21. Хувьцаат капитал

	Эргэлтэд байгаа энгийн хувьцааны тоо ширхэг	Энгийн хувьцаа ₮'000	Нэмж төлөгдсөн капитал ₮'000	Нийт ₮'000
2024.01.01	177,017,600	4,425,440	4,653,188	9,078,628
Хасах нь: Халаасалсан хувьцаа (охин компани эзэмшиж байсан)	(5,620,520)	(140,513)	(1,098,675)	(1,239,188)
2024.12.31	**171,397,080**	**4,284,927**	**3,554,513**	**7,839,440**
Нэмэх нь: Гаргасан хувьцаа (охин компани эзэмшиж байсан)	13,492,080	337,302	1,642,527	1,979,829
2025.12.31	**184,889,160**	**4,622,229**	**5,197,040**	**9,819,269**

Энгийн хувьцаа

Нэгж энгийн хувьцаа бүр нэг саналын эрхтэй, ногдол ашиг зарласан тохиолдолд түүнийг авах эрхтэй ба энгийн хувьцааны нэрлэсэн үнэ 25 төгрөг.

Зөвшөөрөгдсөн хувьцааны тоо 192,166,000 ширхэг, гаргасан хувьцааны тоо 184,889,160 ширхэг. Гаргасан бүх хувьцаа болох 184,889,160 ширхэг хувьцааны төлбөр бүгд бүрэн төлөгдсөн.

Халаасны хувьцаа

Охин компани болох ККТТ ХХК нь толгой компанийн 13,492,080 (2024: 13,492,080) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж байсныг халаасны хувьцаагаар толилуулж байсан.

Тайлант онд эзэмшиж байсан толгой компанийн бүх хувьцааг арилжсан байна.

Халаасны хувьцааны хөдөлгөөнийг харуулбал:

	Хувьцааны тоо ширхэг	Нэрлэсэн үнээр ₮000	Нэмж төлөгдсөн капитал ₮000	Нийт ₮000
2024.01.01	7,871,560	196,789	543,852	740,641
Нэмэгдсэн	5,620,520	140,513	1,098,675	1,239,188
2024.12.31	**13,492,080**	**337,302**	**1,642,527**	**1,979,829**
Арилжсан	(13,492,080)	(337,302)	(1,642,527)	(1,979,829)
2025.12.31	-	-	-	-

Охин компанийн эзэмшиж байсан хувьцааг арилжаалснаас 685,662 мянган төгрөгийн олз олсныг бусад орлогоор толилуулсан. (Тод.7)

21. Хувьцаат капитал (Үргэлжлэл)

Группийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийг тайлант жилүүдээр харуулбал:

№	Нэрс	Бүртгэлтэй улс	Эзэмшиж буй хувь	
			2025.12.31	2024.12.18
1	Халтарын Доржсүрэн	Монгол улс	24.24	-
2	Ай Си Ти Групп ХК	Монгол улс	6.16	-
3	Эн Си Ди Групп ХХК	Монгол улс	12.53	27.45
4	Юнимедиа Солюшнс ХХК	Монгол улс	8.42	8.42
5	Могул ХХК	Монгол улс	8.27	8.27
6	Айкор Партнерс ХХК	Монгол улс	-	7.11
7	Рентракс ХК (Rentracks JSC)	Япон улс	5.61	5.61
8	ККТТ ХХК*	Монгол улс	-	7.30
9	Шагдарсүрэнгийн Энхбаяр	Монгол улс	0.11	10.00
10	Батзоригийн Чулуунсүх	Монгол улс	-	4.81
11	Дамдинсүрэнгийн Даваа	Монгол улс	0.46	3.37
12	Такахиро Ичики (TAKAHIRO)	Япон улс	1.40	1.40
13	Масанори Окоши (MASANORI)	Япон улс	0.00	2.13
14	Шоичиро Ичитани (SHOICHIRO)	Япон улс	1.40	1.40
15	GLOBAL TRUST NETWORKS.; LTD	Монгол улс	1.40	1.40
16	НОБ ХХК (NOB LLC)	Япон улс	1.40	1.40
17	Жавхлангийн Цогтбаяр	Монгол улс	0.93	0.93
18	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК	Монгол улс	1.29	0.55
19	Трай Арк ХХК	Монгол улс	7.01	-
20	Доржсүрэнгийн Цогт Очир	Монгол улс	8.76	-
21	Бусад хувьцаа эзэмшигчид		10.61	8.45
	Нийт		**100**	**100**

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Энгийн хувьцаа - Энгийн хувьцаа нь өмчөөр ангилагддаг. Компаниас гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж өмчийн хэсэгт бүртгэдэг.

Халаасны хувьцаа - Компани болон шууд хяналт хэрэгжүүлдэг холбоотой талууд нь өөрийнхөө өмчийн үнэт цаасыг худалдан авсан тохиолдолд шууд холбогдон гарсан зардлууд болон татварыг хассан дүнгээр эдгээрийг дахин гаргах эсвэл хүчингүй болгох хүртэл өмчийн хэсэгт хасагдах байдлаар тайлагнана.

Нэмж төлөгдсөн капитал - Хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн хэмжээг хэлнэ. Хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр борлуулбал хүлээсэн алдагдлын хэмжээг нэмж төлөгдсөн капитал дансанд сөрөг тэмдэгтэйгээр тайлагнадаг.

Ногдол ашиг - Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох шийдвэр баталгаажсан тайлант үед өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

22. Капиталын удирдлага

Группийн удирдлага, ТУЗ нь хөрөнгө оруулагч, зээлдэгчдийн итгэлийг хадгалах, нэмэгдүүлэх, бизнесийн ирээдүйн тогтвортой хөгжлийг хангахын тулд уян хатан, бат бөх капиталын суурийг хадгалах бий болгох бодлоготой.

Капиталын бүтцийг хадгалах эсвэл сайжруулахын тулд Групп нь хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн дүнг өөрчлөх, хувьцаа гаргах зэрэг арга хэмжээ авдаг. Групп нь цэвэр өрийн хөрөнгөөр санхүүжиж байгаа бөгөөд өрийн хэрэгслээр санхүүжилт ашиглаагүй, санхүүгийн эрсдэл харьцангуй бага байна.

23. Хуримтлагдсан ашиг ба ногдол ашиг

	2025 ₮'000	2024 ₮'000
Хуримтлагдсан ашиг		
01 сарын 01	7,440,476	8,368,940
Зарласан ногдол ашиг	-	(11,394,719)
Охин компанийн эзэмшиж байсан хувьцаанд ногдох ногдол ашгийн тохируулга	269,841	440,101
Тайлант жилийн цэвэр ашиг	13,439,201	10,026,155
12 сарын 31	**21,149,518**	**7,440,476**

Группийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал бөгөөд тайлант жилүүдийн цэвэр ашгаар нэмэгдэж, зарласан ногдол ашгаар буурдаг.

Тайлант жилүүдэд охин компанийн эзэмшиж байсан энгийн хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнгээр хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлж тохируулсан.

Тайлант жилүүдийн ногдол ашгийг дэлгэрэнгүй харуулбал:

	2025 ₮'000	2024 ₮'000
Ногдол ашгийн өглөг		
01 сарын 01	3,697,783	-
2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 21.63 төгрөг	-	3,999,153
2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 20.00 төгрөг	-	3,697,783
2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 20.00 төгрөг	-	3,697,783
Олгосон ногдол ашиг	(3,697,733)	(7,696,936)
12 сарын 31	**50**	**3,697,783**
Үүнээс: Мөнгөөр олгосон	(3,697,733)	(7,696,936)

Тайлант жилийн эцсээс хойш зарласан ногдол ашиг

Балансын өдрөөс хойш Группийн ТУЗ нь 2025 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 50 төгрөг, нийт 9,244,458 мянган төгрөгийн ногдол ашгийг санал болгосныг ер төлбөрөөр хүлээн зөвшөөрөөгүй байна.

24. Бодит үнэ цэний хэмжилт

Групп нь бусад санхүүгийн хөрөнгөөр толилуулсан 744,832 (2024: 744,832) мянган төгрөгийн өмчийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэн (Түвшин 3) -ээр хэмжсэн.

Тайлант жилүүдэд БҮЦ-ийн шатлалын түвшин хооронд шилжүүлэлт хийгдээгүй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Групп нь зарим санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг БҮЦ-ээр хэмждэг. Бодит үнэ цэн нь хэмжилтийн өдрөөрх зах зээлд оролцогчдын хоорондын хэвийн ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх дүн юм. Зах зээлд оролцогчид нь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн үнийг тогтоохдоо өөрсдийн эдийн засгийн ашиг сонирхлыг хамгийн сайнаар хангах байдлаар оролцоно гэж үзээд тухайн хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын хэрэглэх байсан таамаглалуудад үндэслэн БҮЦ-ийг хэмжинэ.

Групп нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаг хөрөнгө, өр төлбөрийг үнэлж байгаа бол тэр идэвхтэй зах зээлийн жишиг үнийг ашиглана. Хэрэв идэвхтэй зах зээл байхгүй бол Групп нь БҮЦ-ийг тодорхойлохдоо тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой бөгөөд ажиглагдах боломжтой орцуудыг хамгийн их, үл ажиглагдах орцуудыг хамгийн бага байлгах үнэлгээний аргачлалуудыг сонгож ашигладаг.

Группийн санхүү эрхэлсэн захирал нь БҮЦ, ялангуяа идэвхтэй зах зээл дээрх шууд ажиглагдах үнээр тодорхойлогдоогүй БҮЦ-ийг тодорхойлохтой холбоотой бодлого, журмыг тодорхойлох үүрэг хүлээдэг.

Үүнд, хэрэв санхүү эрхэлсэн захирал БҮЦ-ийн үнэлгээг групп дотооддоо өөрсдөө хийх мэдлэг, ур чадвар байхгүй гэж үзсэн тохиолдолд гадаад хараат бус үнэлгээчнийг ашиглахаар шийдвэрлэдэг ба гадаад үнэлгээчний бэлтгэсэн үнэлгээг зах зээлийн талаарх өөрсдийн мэдлэг мэдээлэлтэй нийцэж байгаа эсэх, үнэлгээ нь ул үндэслэлтэй эсэхийг үнэлж үздэг.

Групп нь ашигласан үнэлгээний арга аргачлалаа тууштай тогтвортой мөрдөхийг зорьдог ба шинэ аргачлал нь үл ажиглагдах орцуудын ашиглалтыг бууруулж, ажиглагдах орцуудыг илүү ихээр ашигласан зөвхөн тийм тохиолдолд л үнэлгээний аргачлалаа өөрчилдөг.

Бүх үнэлгээг БҮЦ-ийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцуудад үндэслэн дараах гурван түвшинд ангилдаг:

- Түвшин 1 – Ижил төсөөтэй хөрөнгө, өр төлбөрийн хувьд идэвхтэй зах зээлийн жишиг үнэ (тохируулга хийгдээгүй) ашигласан үнэлгээний аргачлал
- Түвшин 2 – Түвшин 1-ийн шаардлагыг хангаснаас бусад шууд болон шууд бус ажиглагдах орцууд ашигласан үнэлгээний аргачлал
- Түвшин 3 – Үл ажиглагдах орцуудыг ашигласан үнэлгээний аргачлал

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

25.1 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээний нөгөө тал нь санхүүгийн хэрэглүүр эсвэл худалдан авагчтай хийсэн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, улмаар Группийг санхүүгийн алдагдалд оруулах эрсдэл юм.

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Групп нь бүх санхүүгийн хөрөнгүүдийнхээ хувьд зээлийн эрсдэлд өртөж болох ба хүлээж болзошгүй алдагдлын дээд хэмжээ нь эдгээр хөрөнгийн дансны үнэ юм.

Зээлийн эрсдэлийг удирдахдаа эрсдэлийн удирдлагын алба нь эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу Группийн хамтран ажиллах бүх санхүүгийн байгууллагыг сонгодог. Ингэснээр мөнгөн хадгаламж болон бусад санхүүгийн хөрөнгийн хувьд найдвартай байгууллагад хадгаламж байршуулах, зээлжих чадвар өндөр, найдвартай харилцагчдад дараа тооцоогоор үйлчилгээ үзүүлэх, өрийн болон өмчийн хэрэглүүрт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, зээлийн эрсдэлийг бууруулдаг.

Группийн ТУЗ нь зээл ба хөрөнгө оруулалтын хамгийн дээд лимитийг тогтоодог ба үүнийг тогтмол хянадаг.

Группийн тухайлсан нэг худалдан авагч эсвэл харилцагч байгууллагын хувьд материаллаг зээлийн эрсдэл үүсээгүй боловч зарим санхүүгийн хөрөнгийн хувьд нийт мөнгөн хөрөнгийн 47 хувийг М банканд байршуулсан, топ 3 харилцагчаас авах авлага нь нийт худалдааны авлагын 40 хувийг бүрдүүлж байна.

Худалдааны болон бусад авлага

Групп зээлийн эрсдэлийг удирдах тодорхой бодлогуудыг хэрэгжүүлдэг ба Санхүү удирдлагын газар эрсдэлийг хянаж удирддаг. Шинэ харилцагчидтай хамтран ажиллахаас өмнө эхлээд тухайн харилцагчийн зээлжих чадвар, үйл ажиллагааг үнэлж, шаардлага хангасан эсэхийг тогтоох зэрэг арга хэмжээ авдаг.

Групп худалдааны авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлохдоо хялбаршуулсан аргыг ашиглах бөгөөд худалдааны болон бусад авлагын насжилтад үндэслэн дараах хувь хэмжээгээр эрсдэлийн сан байгуулдаг.

- 0-3 хүртэл сарын насжилттай авлагын үлдэгдлээс 3 хувь;
- 3-6 хүртэл сарын насжилттай авлагын үлдэгдлээс 5 хувь;
- 6-12 хүртэл сарын насжилттай авлагын үлдэгдлээс 8 хувь;
- 1-2 жилийн насжилттай авлагын үлдэгдлээс 10 хувь;
- 3-4 хүртэл жилийн насжилттай авлагын үлдэгдлээс 25 хувь;
- 4-өөс дээш жилийн насжилттай авлагын үлдэгдлээс 100 хувь.

Хүлээгдэж буй алдагдлын нөөцийг харуулбал:

	Авлагын насжилтаар					
	<90 хоног	**91-180 хоног**	**180-с дээш**	**3-4 жил**	**4-с дээш**	**Нийт**
	₮'000	**₮'000**	**₮'000**	**₮'000**	**₮'000**	**₮'000**
2025						
Хүлээгдэж буй алдагдлын хувь	3%	5-8%	10%	25%	100%	
Худалдааны авлага	2,265,895	238,623	219,590	687	-	**2,724,795**
ХБЗА	49,830	11,931	20,879	172	-	**82,812**
2024						
Хүлээгдэж буй алдагдлын хувь	3%	5-8%	10%	25%	100%	
Худалдааны авлага	2,387,557	60,072	57,725	8,047	10,329	**2,523,730**
ХБЗА	57,146	3,196	5,772	2,625	10,329	**79,068**

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хувь хэмжээг Компани тогтмол хянадаг ба зээлийн алдагдлын нөөцийг тооцоход ашигласан төсөөлөл таамаглалд өөрчлөлт гарвал нөөцийн дүнг материаллагаар өөрчлөхөд хүргэж болно.

Тайлант жилийн хувьд худалдааны авлагатай холбоотой хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

	2025 ₮'000	2024 ₮'000
01 сарын 01	79,068	50,040
Нөөцийн өсөлт (ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн)	76,859	29,028
Цуглуулах боломжгүй болсноор тайлант жилд данснаас хассан авлага	(73,114)	-
12 сарын 31	***82,813***	***79,068***

Групп 90 хоногоос дээш хоногтой авлагуудыг хугацаа хэтэрсэн гэж үздэг бөгөөд авлага эргэн төлөгдөх нь найдваргүй болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон үед шүүхийн шийдвэр, нотолгоог үндэслэн тухайн авлагын шинж чанар, дүнгээс хамаарч холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн данснаас хасдаг.

Групп нь тайлант хугацаанд төлөгдөх найдваргүй 73,114 мянган төгрөгийн дансны авлага данснаас хасаж, нөөц санг бууруулсан бол 11,132 мянган төгрөгийн бусад авлагыг данснаас хасаж, гарзаар хүлээн зөвшөөрсөн. (Тод.8)

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Групп аль болох өндөр кредит үнэлгээтэй, найдвартай санхүүгийн байгууллагад мөнгөн хөрөнгийг байршуулахыг зорьдог ба үнэлгээний байгууллагуудаас зээлжих зэрэглэлийн үнэлгээнд оруулсан өөрчлөлтийг тогтмол хянадаг.

Тайлант оны хувьд Худалдаа Хөгжлийн банк, Хаан банк, М банк дахь мөнгө нийт мөнгөний 80 хувийг эзлэх бөгөөд эдгээр банкнуудын зээлжих зэрэглэлийн үнэлгээний мэдээлэл дараах байдалтай байна:

	Үнэлгээний байгууллага	Зээлжих зэрэглэл[2]
Хаан банк	Moody's	B1 (тогтвортой)[3]
Худалдаа хөгжлийн банк	Moody's	B1 (тогтвортой)
М банк	Moody's	B3 (тогтвортой)
Тээвэр хөгжлийн банк	Fitch ratings	B- (тогтвортой)

Групп мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд 12 сарын хугацааны хүлээгдэж буй алдагдлын аргаар үнэ цэний бууралтын үнэлгээ хийдэг ба 2025 оны 12 сарын 31-нээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөц хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн (2024: 0).

[2] 2024 оны 11 сарын 19-нд зарлагдсан үнэлгээ.
[3] 2025 оны 10 сарын 16-нд зарлагдсан үнэлгээ

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Бусад санхүүгийн хөрөнгүүд

Группийн удирдлагуудын зүгээс хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа санхүүжигчийн төлбөрийн чадвар, зээлжих чадамжийг үнэлэх, төвлөрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор олон төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд тараан байршуулах, нэг санхүүжигчид олгох хөрөнгө оруулалтын дээд хэмжээг хянах, гэрээний нөхцөл, барьцаа, баталгааг шалгах зэрэг хяналт үнэлгээний арга хэмжээг авч хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Тайлант хугацааны эцсээр, дээрх хадгаламж, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), итгэлцлийн хүү ба үндсэн төлбөрүүдэд хугацаа хэтрэлт үүсээгүй, гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөж байгаа бөгөөд Компаниудын удирдлага нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүсээгүй гэж үнэлсэн. (Тод.15)

25.2 Хөрвөх чадварын эрсдэл

Групп нь төрөл бүрийн үүрэг амлалтыг хүлээдэг бөгөөд эдгээрийг цаг хугацаанд нь биелүүлэхэд шаардлагатай богино хугацаат санхүүгийн хэрэгцээг хангах чадваргүй болж болзошгүй эрсдэлийг хөрвөх чадварын эрсдэл гэнэ.

Групп нь мөнгөн урсгалын таамаглалыг хянах, ашиглаагүй зээлийн үлдэгдлийг хангалттай хэмжээнд байлгах замаар хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг. Компанийн Санхүү удирдлагын газар үйл ажиллагааны сегмент бүрээрх мөнгөн урсгалын прогноз хийж шаардлагатай мөнгөн хөрөнгө байгаа эсэхийг хянаж ажилладаг.

Дараах хүснэгтэд Группийн санхүүгийн өр төлбөрүүдийн гэрээний дагуух хүү ба үндсэн төлбөрийн хорогдуулаагүй мөнгөн урсгалыг 12 сарын 31-нээрх тэдгээрийн гэрээний хугацаанд үндэслэн харуулав.

	Дансны үнэ	Нийт	0-3 сар	12 сар	1-3 жил
	₮'000	₮'000	₮'000	₮'000	₮'000
2025					
Санхүүгийн өр төлбөр					
Худалдааны өглөг	2,344,631	2,344,631	2,344,631	-	-
Түрээсийн өр төлбөр	873,089	999,416	129,192	370,370	499,854
Ногдол ашгийн өр	54	54	54	-	-
	3,217,774	**3,344,101**	**2,473,877**	**370,370**	**499,584**
2024					
Санхүүгийн өр төлбөр					
Худалдааны өглөг	2,269,607	2,269,607	2,269,607	-	-
Ногдол ашгийн өр	3,697,783	3,697,783	3,697,783	-	-
Татварын өр	392,494	392,494	392,494		
	6,359,884	**6,359,884**	**6,359,884**		

25.3 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн үнийг дагаж санхүүгийн хэрэглүүрүүдийн БҮЦ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал өөрчлөгдсөний улмаас Групп нь зах зээлийн эрсдэлд өртөж болно. Группийн өртөж болох зах зээлийн эрсдэлүүд нь гадаад валютын ханшийн ба хүүгийн түвшний өөрчлөлт гэж үзсэн.

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Группийн санхүү эрхэлсэн захирал болон эрсдэлийн удирдлагын хороо нь зах зээлийн эрсдэлийг удирдаж хяналт тавьдаг. Тайлант жилүүдэд эрсдэлийн удирдлагын бодлогод өөрчлөлт ороогүй ба 2024, 2025 онуудад тууштай мөрдөгдсөн.

Валютын ханшийн эрсдэл

Групп нь бүртгэлийн валютаас өөр валютаар хийсэн борлуулалт, худалдан авалт, авлага, өр төлбөр эсвэл хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас гадаад валютын ханшийн эрсдэлд өртдөг. Группийн санхүүгийн алба нь валютын ханшийн эрсдэлийг хянаж удирддаг бөгөөд эрсдэлээс сэргийлэх арга хэмжээнүүд авдаг.

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцсээрх Группийн валютын ханшийн эрсдэлтэй дүнгүүдийг харуулав.

USD

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	88,987	989,642
Бусад санхүүгийн хөрөнгө (хадгаламж)	981,638	-
Бусад авлага	15,793	14,470
Валютын ханшийн эрсдэлд өртөх цэвэр дүн	**1,086,418**	**1,004,112**

Группийн ашигладаг гадаад валютын ханшийн ул үндэслэлтэй боломжит хэлбэлзлийн хэмжээ 10 хувь гэж үзсэн.

Группийн бүртгэлийн валют болох төгрөгийн гадаад валюттай харьцах хаалтын ханш 12 сарын 31-нээр 10 хувиар чангарахад Группийн ашиг алдагдалд 108,462 (2024: 100,411) мянган төгрөг, өмчид 84,481 (2024: 75,308) мянган төгрөгөөр нөлөөлнө. Төгрөгийн уг валюттай харьцах хаалтын ханш 10 хувь сулрахад энэ нь ашиг алдагдал, өмчид дээрх дүнгүүдээр эсрэгээр нөлөөлнө.

Энэхүү мэдрэмтгий байдлын шинжилгээг хүүгийн түвшин зэрэг валютын ханшаас бусад хувьсагчид нь өөрчлөгдөхгүй гэж төсөөлөн хийсэн болно.

Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний өөрчлөлтөөс үүдэн хүүтэй хэрэглүүрүүдийн мөнгөн урсгал хэлбэлзсэнээр уг эрсдэлд өртдөг. Энэ нь Группийн хувьд хугацаатай хадгаламж, бондоорх хөрөнгө оруулалт болон түрээсийн өр төлбөрүүдээс үүсдэг.

Группийн эрсдэлийн удирдлагын хороо нь энэ эрсдэлд хяналт тавьж удирддаг ба эрсдэлээс сэргийлэх, боломжит түвшин хүртэл бууруулахын тулд хадгаламжийн хугацаа, зарлага гаргах эрхийг уян хатан байдлаар тохирох, тараан байршуулах зэрэг арга хэмжээ авдаг.

Тайлагналын өдрөөр Группийн ашигладаг тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн түвшин 7-19 хувийн хооронд байсан.

Бүх тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгслүүд нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хэрэгслүүд. Тайлант онд ямар нэг хүүтэй холбоотой своп хэлцэл Компани хийгээгүй.

Хугацаатай хадгаламжуудыг хугацаанаас өмнө цуцалбал хүүгийн түвшин жилийн 2 хувь болж буурах нөхцөлтэй боловч Группийн удирдлага хадгаламжийг дуусах хугацаа хүртэл хадгална гэсэн хүлээлттэй байна.

25. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Тайлагналын өдрөөр хүүгийн түвшний эрсдэлд өртөж болохуйц Группийн тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгслүүд нь дараах байдалтай байсан.

	2025.12.31 ₮'000	2024.12.31 ₮'000
Тогтмол хүүтэй хэрэгслүүд:		
Богино хугацаатай хадгаламж (7%-18%) (Тод.11)	19,342,295	8,381,761
Ажилчдад олгосон зээл (6%) (Тод.14)	75,693	-
Бусад санхүүгийн хөрөнгө (Тод.15)	2,081,638	200,000
Урт хугацаат хөрөнгө оруулалт (Тод.16)	669,400	1,250,000
Санхүүгийн хөрөнгө	*22,169,026*	*9,831,761*
Түрээсийн өр төлбөр (16.6%) (Тод.19)	873,089	-
Санхүүгийн өр төлбөр	873,089	-
Хүүгийн түвшний эрсдэлд өртөх цэвэр дүн	**21,295,937**	**9,831,761**

Хүүгийн түвшний өөрчлөлт нь Группийн ашиг алдагдал болон өмчид нөлөөлнө. Групп 12 сарын 31-нээр хүүгийн түвшний ул үндэслэлтэй боломжит өөрчлөлтийн хэмжээ 5 хувь гэж үзсэн.

Хэрэв хүүгийн түвшин энэ хувиар өсвөл (буурвал), валютын ханш гэх мэт бусад бүх хүчин зүйлс өөрчлөгдөхгүй хэвээрээ гэж үзвэл ашиг алдагдалд үзүүлэх нөлөө 93,917 (2024: 80,324) мянган төгрөг, өмчид үзүүлэх нөлөө 70,438 (2024: 60,243) мянган төгрөг байна.

26. Холбоотой талууд

Групп нь өөр аж ахуйн нэгжийн санхүүгийн болон удирдлагын шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх, эсвэл хяналт тавих эрхтэй бол холбоотой талууд болно. Хэрвээ эсрэгээрээ буюу компанийн санхүүгийн болон удирдлагын шийдвэр гаргалтад хувь хүн эсвэл өөр аж ахуйн нэгж шууд ба шууд бусаар нөлөө үзүүлдэг, эсвэл хяналт тавьдаг бол мөн холбоотой талууд гэж тодорхойлдог.

Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад компаниуд байж болно.

Компанийн шууд болон эцсийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн гэр бүлийн ойр дотнын гишүүд; болон гол хувьцаа эзэмшигчдийн хяналтад байдаг эсвэл тэдгээрийн мэдэгдэхүйц нөлөөтэй аж ахуйн нэгжүүд нь мөн холбоотой талууд байж болно.

Холбоотой талуудыг жагсаалтаар харуулбал:
Охин компаниуд

	Бүртгэгдсэн улс, Харьяалал	Үйл ажиллагааны чиглэл	Харилцан хамаарал
ККТТ ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Компьютерын программчлал	Энгийн хувьцааг 100% эзэмшдэг
Дижитал мерчант сервисэс ХХК	Монгол улсын хуулийн этгээд	Мэдээллийн технологийн зөвлөгөө үйлчилгээ	Энгийн хувьцааг 100% эзэмшдэг

26. Холбоотой талууд (Үргэлжлэл)

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид ба түүнд хамаарах холбоотой тал

	Эзэмшиж буй хувь	Бүртгэгдсэн улс, Харьяалал	Үйл ажиллагааны чиглэл
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид			
Халтарын Доржсүрэн	24.24	Монгол улс	-
Эн Си Ди Групп ХХК	12.53	Монгол улс	Барилгын засвар, худалдаа
Доржсүрэнгийн Цогт-Очир	8.76	Монгол улс	-
Юнимедиа Солюшнс ХХК	8.42	Монгол улс	Компьютерын программчлал, мэдээллийн технологийн үйлчилгээ
Могул ХХК	8.27	Монгол улс	Компьютер, электрон тоног төхөөрөмжийн угсралт, үйлдвэрлэл худалдаа
Трай арк ХХК	7.01	Монгол улс	Худалдаа
Ай Си Ти Групп ХХК	6.16	Монгол улс	Мэдээллийн технологи
Рентракс ХК (Rentracks JSC)	5.61	Япон улс	Медиа
Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хяналтад байдаг холбоотой талууд			
Ай ти зон ХХК	-	Монгол улс	Компьютерын техник хэрэгслийн худалдаа
Инвескор капитал ҮЦК ХХК	-	Монгол улс	Хөрөнгийн менежмент

Эрх бүхий албан тушаалтан

Нэр	Томилогдсон огноо	Албан тушаал
Төлөөлөн удирдах зөвлөл		
А. Баттамир	2024.04.28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 01/03 тогтоол	Эцсийн өмчлөгч бөгөөд ТУЗ-ийн дарга
Б. Анхболд		ТУЗ-ийн ердийн гишүүн
Б. Чулуунсүх		ТУЗ-ийн ердийн гишүүн
Г. Хатанболд		ТУЗ-ийн ердийн гишүүн
У. Мөнхзул		ТУЗ-ийн ердийн гишүүн
У. Наранбаатар		ТУЗ-ийн ердийн гишүүн
Т. Дашцэрэн		ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ш. Уянга		ТУЗ-ийн хараат бус гишүүн
Б. Нандин Эрдэнэ[4]	2025.05.28 ТУЗ	ТУЗ-ийн хараат бус гишүүн - түр
О. Маралмаа	2025.06.01 ТУЗ	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

[4] ТУЗ-ийн 2025.05.28-ны өдрийн 05/42 дугаар тогтоолоор өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн хараат бус гишүүний оронд нөхөн сонгууль болтол түр томилогдсон.

26. Холбоотой талууд (Үргэлжлэл)

Нэр	Томилогдсон огноо	Албан тушаал
Гүйцэтгэх удирдлага		
Б. Энхболд[5]	2025.07.07	Гүйцэтгэх захирал
Н. Жавхлан	2025.07.07	ККТТ ХХК-ийн гүйцэтгэх захирал
Д. Жанчив	2017 оноос	Технологи хариуцсан захирал
Ц. Гомбодорж	2022 оноос	Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал
О. Хонгор	2017 оноос	Бизнес хөгжил хариуцсан захирал
С. Ундармаа	2025.07 сараас	Ерөнхий нягтлан бодогч

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

	2025 ₮'000	2024 ₮'000
ТУЗ-ийн цалин	178,734	56,800
Гүйцэтгэх удирдлагын багийн цалин	857,662	498,907
Гүйцэтгэх удирдлагын багт олгосон 2024 оны гүйцэтгэлийн урамшуулал	459,990	-
Гүйцэтгэх удирдлагын багт олгосон 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн урамшуулал	74,359	-

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.05.28-ны өдрийн 05/45 дугаар тогтоолоор 2024 оны группийн гүйцэтгэлийн урамшууллын багцыг 578,000 мянган төгрөгөөр баталж, эхний хагас жилийн урамшууллаар тооцож олгосон 45,112 мянган төгрөгийг суутгаж, үлдэх 532,888 мянган төгрөгийн олгохоор шийдвэрлэсэн байна.

Мөн 2025.10.08-ны өдрийн 10/67 дугаар тогтоолоор 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн урамшууллын багцыг 139,198 мянган төгрөгөөр, 2025.10.08-ны өдрийн 10/68 дугаар тогтоолоор гүйцэтгэх захиралд олгох 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн урамшууллыг 64,621 мянган төгрөгөөр тус тус тогтоож олгосон байна.

Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Групп нь охин компани болох ККТТ ХХК-аас сар бүр 100,000 (2024: 50,000), Дижитал мерчант сервисэс ХХК -аас сар бүр 10,000 (2024: 5,000) мянган төгрөгийн менежментийн үйлчилгээ үзүүлсний төлбөрийг авдаг ба уг ажил гүйлгээтэй хамаарах авлага, өр төлбөрийн тооцоо байхгүй.

Бусад шаардлага

Харилцан хамааралтай талуудтай хийх ажил гүйлгээг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцож, Төлөөлөн удирдах зөвлөл зөвшөөрөл олгодог.

Холбоотой талуудтай хийсэн бусад бүх ажил гүйлгээг талууд харилцан зөвшилцсөн нөхцөлөөр хийсэн.

[5] Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.07.07 өдрийн 07/58 дугаар тогтоолоор Ө.Эрдэнэмөнхийг гүйцэтгэх захирлаас чөлөөлж, Санхүү хариуцсан захирал Н.Энхболдыг гүйцэтгэх захирлаар томилсон.

27. Үүрэг хариуцлага ба бусад хуулийн шаардлага

Групп нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Кибер аюулгүй байдлын тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй.

Тайлант онд ККТТ ХХК-ийн цахим төлбөр тооцооны систем, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилтэд Франц улсын Афнор байгууллагын итгэмжлэлээр МонсертФ ХХК-аар ISO 27001:2022 стандартын магадлах аудитыг хийлгэсэн. Гэрчилгээний хүчинтэй хугацаа 2025-08-12 өдрөөс 2027-04-24 хүртэл байна.

28. Балансын дараах үйл явдал

Тайлант үеийн эцсээс хойш 2025 оны санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй дараах үйл явдлууд тохиолдсон.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 26/05 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зарласан.
- Ногдол ашгийн мэдээллийг Тодруулга 22-оос харна уу.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэснээс хойш Толгой компанийн шийдвэрээр ККТТ ХХК нь 2025 оны цэвэр ашгаас 9,000,000 мянган төгрөг, Дижитал мерчант сервисес ХХК нь цэвэр ашгаас 2,500,000 мянган төгрөгийн ногдол ашиг Инновэйшн инвестмент ХК-д олгоно.

MOORE

